МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвсүрэнгийн НАРАНБАЯР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 48 59, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: naranbayar@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.11.05 № УИХ-03/12495

танай _____-ны №_____-т

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
М.МӨНХБАТ ТАНАА

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь хэсэгт заасны дагуу танай байгууллагаас санал авахаар хүргүүлж байна.

Иймд тус хуулийн төсөлтэй танилцан, саналаа ирүүлэхийг хүсье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох тайлан судалгааг хавсаргав.

Хавсралт 90 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН П.НАРАНБАЯР

2026000596

БАТЛАВ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.НАРАНБАЯР

2026 оны 10 сарын 23-ний өдөр

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн." гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх" гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтууд эх орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг болохыг, иргэн хууль дээдлэн сахих үндсэн үүрэгтэйг, мөн төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгаа бүрдүүлэх үүрэгтэйг тус тус тогтоосон.

Эдгээр үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхдээ зөрчилд хүлээлгэх хариуцлага нь зөрчлийн шинж, нийгмийн хор аюул, учирсан хохирол, хор уршигт нийцсэн, урьдчилан сэргийлэх зорилгод чиглэсэн, хүний эрхэд халдах нь зайлшгүй бөгөөд зохистой хэмжээнд байх шаардлагатай.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д шийтгэл оногдуулах механизмыг боловсронгуй болгох, шийтгэлээс чөлөөлөх болон хөнгөрүүлэх үндэслэлийг шинээр тогтоох, зарим зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгах боломж олгох, зөрчилд тооцох үйлдлийг цөөрүүлэх, хэт ерөнхий зохицуулалттыг тодорхой болгох чиглэлийг Засгийн газарт өгч байсан боловч өнөөдрийг хүртэл шийтгэл оногдуулах механизмыг сайжруулах замаар зөрчлийн тоог цөөрүүлэх, сануулах шийтгэлийг нэвтрүүлэх асуудал шийдэгдээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1.7-д "Төрөөс шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллана." гэж тусгасан байна.

Иймхүү Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хүний эрх, эрх чөлөөг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах төрийн үүргийг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахуйц зарим зөрчилд "сануулах шийтгэл" оногдуулах асуудлыг Зөрчлийн тухай хуульд тусгах хэрэгцээ, шаардлага байна.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино. Гэвч одоо мөрдөж байгаа зохицуулалтаар зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах шийтгэлд сануулах арга хэмжээ бие даасан шийтгэлийн хэлбэрээр байхгүй, улмаар нийгэмд учруулсан хор аюул, хохирол, зөрчлийн шинж чанар, анх удаа зөрчил үйлдсэн эсэх зэрэг нөхцөл байдлыг харгалзан хариуцлагыг шатлан хэрэглэх боломж хязгаарлагдмал байна.

1.2. Практик шаардлага

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад зарим төрлийн зөрчилд зөрчлийн шинж, учирсан хохирол, хор уршиг, зөрчил үйлдсэн этгээдийн өмнөх зан төлөвийг ялгамжтай үнэлэлгүйгээр торгох шийтгэл шууд оногдуулах нөхцөл үүсдэг, түүнчлэн торгуулийн биелэлт хангалтгүй зэрэг асуудал хөндөгдсөөр иржээ[1].

Ийм учраас Монгол Улсын Засгийн газраас 2022 онд боловсруулж, өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл[2]-д мөн зөрчлийг шууд торгохоос илүүтэй зөвлөн туслах, сануулах, зөрчлийн хор уршгийг арилгах боломж олгох тогтолцоог бий болгох зорилтыг тусгаж байсан байна. Гэвч уг шинэчилсэн найруулгын төсөл Улсын Их Хурлаар эцэслэн батлагдаагүй бөгөөд 2020-2024 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбоотойгоор буцаагдсан байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд зөрчлийн харилцааг зохицуулах нэгтгэсэн хууль болох Зөрчлийн тухай хуулийг 2017 онд батлан гаргасан. Уг хуулиар нийт 2300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах зохицуулалттай байна.

---

[1] Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, 2026 он

[2] https://parliament.mn/news/ulsyn-ikh-khurald-orgon-meduulsen-tosluud

Хууль батлагдсанаас хойш буюу 2021 оноос 2025 оныг хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нийт 16,064,538 зөрчил бүртгэж, шийтгэл оногдуулсан байна. Сүүлийн таван жилд дунджаар 3,212,907 зөрчил бүртгэгдэж байсан бол 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4,353,418 зөрчил бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.4 дахин өссөн үзүүлэлт гарчээ. Үүнд нийт 4,141,611 хүн, 178,341 хуулийн этгээдэд нийт 114.3 тэрбум төгрөгийн торгох шийтгэл оногдож, үүнээс 51.0 хувь буюу 58.3 тэрбум төгрөг нь төлөгдсөн байна.

Аливаа хууль тогтоомжийн шийтгэлийн зорилго нь цээрлүүлэхээс гадна урьдчилан сэргийлэх зорилготой байдаг. Шийтгэлийн төрөл нь цөөн байснаар Зөрчлийн хууль хатуу чанга байна гэх шүүмжлэл гардаг байна. Одоогийн хүчин төгөлдөр Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд *торгох, баривчлах, эрх хасах* гэсэн 3 шийтгэлийн төрөлтэй байхаар хуульчилсан. Үүнийг бусад оронтой харьцуулж үзэхэд харьцангуй цөөн байдлаар хуульчлагдсан байна гэж судлаачид дүгнэдэг.[3] Эндээс үзэхэд зөрчилд ногдуулж байгаа торгууль, шийтгэлийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагатай байна. Түүнчлэн нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршгийг шууд учруулаагүй, эсхүл даруй арилгах боломжтой зөрчлүүдэд сануулах шийтгэлийг оногдуулах зохицуулалтыг бий болгох талаар Зөрчлийн тухай хуулийг хэрэглэдэг болон хэрэгжүүлдэг этгээд болох Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар болон иргэд, байгууллагаас хүсэлт, санал шаардлагыг гаргадаг байна.

Иймд нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршгийг шууд учруулаагүй, эсхүл даруй арилгах боломжтой зөрчлүүдэд сануулах шийтгэлийг оногдуулах зохицуулалтыг бий болгож, түүнийг хэрэгжүүлэх журмыг хуульчилж өгөх шаардлагатай байна.

Сануулах шийтгэлийг бий болгосноор бүх зөрчилд торгууль ногдуулах зарчмыг өөрчлөхгүй. Харин Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид тусгайлан заасан, нийгмийн хор аюул багатай, хуульд тогтоосон шалгуурыг хангасан зөрчилд л сануулах шийтгэл хэрэглэх боломж бүрдэнэ. Ингэснээр зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон хариуцлагыг сонгох, хууль сахих зан төлөвийг төлөвшүүлэх, давтан зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалт бий болно.

Хоёр. Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршгийг шууд учруулаагүй, даруй арилгах боломжтой зөрчлүүдэд шууд хатуу торгох шийтгэл оногдуулахаас өмнө "сануулах шийтгэл"-ийг оногдуулах эрх зүйн үндэслэл, нөхцөл, журмыг бий болгоход оршино. Ингэснээр зөрчилд оногдуулах шийтгэлийг зөрчлийн шинж, нийгмийн хор аюул, хохирол, хор уршигт нийцүүлэн шаталсан байдлаар

[3] Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил сануулах арга хэмжээ хэрэглэх боломж, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, 2026 он

хэрэглэх, бага зэргийн шинжтэй, хохирол, хор уршиг учруулаагүй, анх удаа үйлдсэн зөрчилд мөнгөн торгуулийг заавал хэрэглэхээс өмнө сануулах боломж бүрдүүлэх юм.

Хуулийн төслийн үндсэн зохицуулалт нь зөрчил болон шийтгэл нь хуульд заасан байх, шаталсан бөгөөд зохистой хариуцлагын шинжтэй байх, давтан зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байх гэсэн үндсэн зарчимд тулгуурлаж байна.

Хуулийн төслийг 3 зүйл, 10 заалттай байхаар боловсруулах бөгөөд дараах асуудлуудыг тусгана.

Нэгдүгээрт; Зөрчлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйл шийтгэлийн төрөлд "сануулах шийтгэл"-ийг нэмэх, сануулах шийтгэлийн ойлголт, агуулгыг тодорхойлох;

Хоёрдугаарт; сануулах шийтгэлийг оногдуулж болох зөрчлийн төрлүүдийг зааж өгсөн зохицуулалтыг тусгах;

Гуравдугаарт; сануулах шийтгэлийг оногдуулах нөхцөл, шалгуурыг тодорхойлж өгөх;

Дөрөвдүгээрт; сануулах шийтгэлийг зөрчлийн мэдээллийн санд бүртгэх, сануулах шийтгэл оногдуулсан тохиолдолд зөрчлийг дахин үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг тодорхой болгох зохицуулалтуудыг тус тус тусгана.

Хуулийн төсөлд сануулах шийтгэлийг дараах агуулгаар тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна. "Сануулах шийтгэл" гэж энэ хуулийн тусгай ангид заасан зөрчлийг анх удаа үйлдсэн, уг зөрчлөөс хохирол, хор уршиг учраагүй буюу бага хэмжээний хохирол, хор уршиг учирсан зөрчлийг арилгах боломжтой тохиолдолд зөрчил үйлдсэн этгээдэд зөрчлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлан ойлгуулж, зөрчлийг дахин үйлдэхгүй байхыг анхааруулсан шийтгэлийг ойлгоно гэж тусгахаар төлөвлөв.

Сануулах шийтгэл нь торгуулийг орлох автомат арга хэмжээ биш, зөвхөн хуульд тусгайлан заасан зөрчилд, хуульд тогтоосон нөхцөлөөр хэрэглэгдэхээр тодорхойлов. Ингэхдээ тухайн зөрчлийг анх удаа үйлдсэн эсэх, хүний эрүүл мэнд, амь нас, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд хохирол, хор уршиг учирсан эсэх, учирсан хохирол, хор уршгийн хэмжээ; зөрчлийг нэн даруй арилгах боломжтой эсэх; зөрчил үйлдсэн этгээд зөрчлөө хүлээн зөвшөөрч, арилгах арга хэмжээ авсан эсэх; тухайн зөрчлийн нийгмийн хор аюулын шинж, хэмжээ зэрэг нөхцөлийг харгалзах нь зүйтэй юм.

Харин хүний амь нас, эрүүл мэндэд бодит аюул учруулсан, их хэмжээний хохирол бий болгосон, санаатайгаар давтан үйлдсэн зэрэг зөрчилд сануулах шийтгэл хэрэглэхгүй байхаар тусгай ангид ялгамжтай зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Сануулах шийтгэл бий болсноор хууль зүйн үр дагаврын хувьд зөрчлийн хариуцлагын тогтолцоо илүү шаталсан болж, зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон шийтгэл сонгох эрх зүйн боломж нэмэгдэнэ.

Зөрчил үйлдсэн этгээдэд хуулийн үр дагаврыг тайлбарлан ойлгуулах, зөрчлийг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн механизм бий болох юм.

Иргэн, хуулийн этгээдэд бага зэргийн шинжтэй, анх удаагийн зөрчлийн улмаас шууд мөнгөн торгууль хүлээлгэхээс илүүтэйгээр хууль сахих зан төлөвийг төлөвшүүлэх, зөрчлийг дахин гаргахгүй байх боломж бүрдэнэ.

Эдийн засгийн үр дагаврын хувьд зөрчил бүрд шууд мөнгөн торгууль ногдуулахгүй болсноор иргэн, хуулийн этгээдэд ногдох зарим торгуулийн дарамт буурах боломжтой.

Дөрөв. Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахдаа зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээг харгалзах зарчим аль хэдийн тусгагдсан бөгөөд шинэ зохицуулалт нь энэхүү зарчмыг илүү бодитой хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Хуулийн төсөлтэй уялдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3.3 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1.5 дахь заалт:

"1.5. Сануулах шийтгэл"

2/3.11 дүгээр зүйл.Сануулах шийтгэл

"1.Эрх бүхий албан тушаалтнаас зөрчил гаргасан этгээдэд тухайн зөрчлийн хууль зүйн үр дагаварыг тайлбарлаж, дахин гаргахгүй байхыг анхааруулсан мэдэгдлийг сануулах шийтгэл гэнэ.

2.Сануулах шийтгэлийг зөвхөн энэ хуулийн тусгай ангид оногдуулж болохоор заасан тохиолдолд хэрэглэнэ.

3.Сануулах шийтгэлийн хэлбэр нь цаасан болон цахим хэлбэртэй байж болох ба эрх бүхий албан тушаалтан хуульд заасны дагуу хэрэглэнэ.

4.Сануулах шийтгэлийг эрх бүхий албан тушаалтнаас зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

5.Дараах нөхцлийг харгалзан сануулах шийтгэл оногдуулж болно.

5.1.Зөрчлийг анх удаа үйлдсэн.

5.2.Зөрчил нь хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учруулаагүй.

5.3.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд зөрчлийн үр дагаврыг сайн дураар, нэн даруй арилгасан.

6.Сануулах шийтгэл оногдуулсан нь тухайн этгээдэд зөрчил дахин үйлдсэн тохиолдолд хуульд заасан бусад шийтгэл оногдуулахад саад болохгүй.

7.Сануулах шийтгэлийг энэ хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу эрх бүхий албан тушаалтан оногдуулна.

8.Сануулах шийтгэлийг энэ хуульд заасан арваас таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд оногдуулна."

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “баривчлах” гэсний дараа “,сануулах” гэж нэмэх.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.9 дэх заалт:

"1.8.Зөрчлийн тухай хуулийн 3.11 дүгээр зүйлд заасан сануулах шийтгэл оногдуулах нөхцөл, үндэслэл хангагдсан эсэх;

1.9.Сануулах шийтгэл оногдуулах нөхцөл, үндэслэл хангагдсан боловч уг шийтгэлийг оногдуулахгүйгээр өөр төрлийн шийтгэл оногдуулж байгаа бол түүний хууль зүйн болон бодит үндэслэл."

2/7.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

"9.Сануулах шийтгэл оногдуулсан бол шийдвэрт сануулах шийтгэл оногдуулсан хууль зүйн болон бодит үндэслэл, зөрчлийн хууль зүйн үр дагавар, зөрчлийг дахин үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарласан байна."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн зөрчилд сануулах шийтгэлийг хэрэглэхгүй.

2 дугаар зүйл.Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон шийтгэлийн хуудасны маягт, программ хангамжид холбогдох өөрчлөлтийг 2027 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийж бэлэн болгосон байна.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон шийтгэлийг ялгамжтай, шаталсан байдлаар хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах төрийн үүргийг, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт иргэний хууль дээдлэн сахин биелүүлэх, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүргийг тус тус баталгаажуулсан.[1] Эдгээр зохицуулалт нь зөрчлийн хариуцлагын тогтолцоог нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой уялдуулан боловсронгуй болгох эрх зүйн суурь үндэслэл болж байна.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д шийтгэл оногдуулах механизмыг боловсронгуй болгох, шийтгэлийг хөнгөрүүлэх үндэслэлийг тодорхойлох, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгах боломж олгох чиглэлийг тусгасан.[2] Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.7-д төрөөс шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллахаар заасан.[3]

Монгол Улсын Их Хурлаас Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлаж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлсэн. Тус хуулийн 3.3 дугаар зүйлд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийг хуульчилсан боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон тусгаагүй байна.[4] Иймээс зөрчлийг анх удаа үйлдсэн, бодит хохирол, хор уршиг учруулаагүй, эсхүл зөрчлийн үр дагаврыг нэн даруй арилгасан зэрэг нөхцөлийг харгалзан тодорхой төрлийн зөрчилд мөнгөн бус шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсжээ.

Сануулах шийтгэл гэж зөрчил үйлдсэн нь тогтоогдсон хүн, хуулийн этгээдэд тухайн зөрчлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлаж, дахин зөрчил үйлдэхгүй байхыг анхааруулсан хариуцлагын төрөл юм. Иймд уг шийтгэл нь төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлдэг зөвлөн туслах, урьдчилан сануулах, албан шаардлага өгөх арга хэмжээнээс эрх зүйн шинж, хэрэглэх үндэслэл, үр дагаврааараа ялгаатай байна.

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Арван нэгдүгээр зүйлийн 1, Арван долдугаар зүйлийн 1, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

[2] Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл".

[3] Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, "Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", 4.1.1.7 дахь заалт.

[4] Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2017 оны 5 дугаар сарын 11, 3.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг

Улсын Их Хурлын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс 2026 онд боловсруулсан "Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж" судалгаанд Зөрчлийн тухай хуулийн 1,979 зохицуулалтыг шинжилснээс 1,062 буюу 53.7 хувьд зөвхөн торгох шийтгэл, 900 буюу 45.5 хувьд торгох шийтгэлийг бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр тусгасныг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамруулсан зохицуулалтын 99.1 хувьд торгох шийтгэл дангаар буюу бусад арга хэмжээтэй хослон тусгагдсан байна.[5] Энэ нь бодит хэрэгт торгуулийн шийтгэл оногдуулсан давтамж бус, хуульд туссан зохицуулалтын харьцааг илэрхийлнэ.

Зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээллээр 2021–2025 онд нийт 16,064,538 зөрчил бүртгэгдэж, шийтгэл оногдуулсан бөгөөд жилд дундажаар 3.2 сая зөрчил бүртгэгдэж байна. Харин 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4,353,418 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.4 дахин өссөн үзүүлэлт юм.[6] Мөн энэ хугацаанд 4,141,611 хүн, 178,341 хуулийн этгээдэд нийт 114.3 тэрбум төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 58.3 тэрбум төгрөг буюу 51.0 хувь нь төлөгджээ.[7] Эдгээр мэдээлэл нь зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн хэмжээ, торгуулийн биелэлт болон хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг судлах үндэслэл болж байна.

Сануулах шийтгэлийг нэвтрүүлэх асуудлыг өмнөх хууль тогтоомжийн төслийн хүрээнд мөн боловсруулж байжээ. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгах боломж олгох, сануулах шийтгэл нэвтрүүлэх зохицуулалтыг тусгасан боловч уг төсөл эцэслэн батлагдаагүй байна.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах хүрээнд одоогийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр хадгалах, олон нийтийг соён гэгээрүүлэх, захиргааны болон зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, сануулах шийтгэлийг хуульчлах гэсэн дөрвөн хувилбарыг харьцуулан үнэлсэн. Судалгааны үр дүнд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх нь зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхэд шууд чиглэсэн хувилбар гэж үзэж, уг хувилбарт үндэслэн хуулийн төслийг боловсруулаа.[8]

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор 2026 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд иргэдийн цахим санал асуулга явуулсан бөгөөд 2026 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаар нийт 993 иргэн оролцсон байна. Санал асуулгаар анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх боломж, уг шийтгэлийг хэрэглэхэд тохирох нөхцөл, шалгуур, хамруулах зөрчлийн төрөл, хэрэглэх давтамж болон хэрэгжүүлэх хэлбэрийн талаар иргэдийн саналыг авч нэгтгэсэн. Судалгааны үр дүнг сануулах шийтгэлийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага болон хуулийн төслийн зохицуулалтын хувилбарыг тодорхойлоход харгалзан үзсэн болно.

---

[5] Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, "Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж", 2026 он, шийтгэлийн төрлийн ангиллын хүснэгт.

[6] Улсын ерөнхий прокурорын газрын 2026 оны эхний хагас жилийн статистик мэдээлэл.

[7] Торгуулийн биелэлтийн талаарх холбогдох байгууллагын статистик мэдээлэл.

Гадаад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаагаар Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Португал, Их Британи, Франц Улсын холбогдох зохицуулалтыг авч үзэж, зөрчлийн шинж, хор уршиг, давтан үйлдсэн байдал, зөрчлийг арилгах боломжийг харгалзан сануулах болон бусад хариуцлагын арга хэмжээ хэрэглэх туршлагыг судалсан. Эдгээр улсын зохицуулалт нь эрх зүйн шинж, нөхцөл, үр дагавраараа ялгаатай боловч хариуцлагыг зөрчлийн онцлогт тохируулан хэрэглэх боломжийг харьцуулан судлах ач холбогдолтой юм.

Дээрх хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны үр дүнд үндэслэн Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх, түүний ойлголт, хэрэглэх нөхцөл, хэлбэр, бүртгэл болон эрх зүйн үр дагаврыг тодорхойлох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл нь гурван зүйлээс бүрдэх бөгөөд дараах үндсэн зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сануулах шийтгэлийг нэмж, шинээр 3.11 дүгээр зүйлээр уг шийтгэлийн ойлголт, хэрэглэх нөхцөл, хэлбэр, бүртгэл болон эрх зүйн үр дагаврыг зохицуулахаар тусгасан.

Сануулах шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдсэн этгээдэд тухайн зөрчлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлаж, дахин зөрчил үйлдэхгүй байхыг анхааруулсан мэдэгдэл байхаар тодорхойлсон. Уг шийтгэлийг зөвхөн Зөрчлийн тухай хуулийн Тусгай ангид оногдуулж болохоор заасан тохиолдолд хэрэглэхээр, цаасан болон цахим хэлбэрээр оногдуулж, зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэхээр тусгалаа.

Сануулах шийтгэл оногдуулахдаа зөрчлийг анх удаа үйлдсэн эсэх, тухайн зөрчил хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учруулсан эсэх, зөрчлийн үр дагаврыг сайн дураар нэн даруй арилгасан эсэхийг харгалзан үзэхээр тусгасан. Мөн сануулах шийтгэл оногдуулсан нь тухайн этгээд зөрчлийг дахин үйлдсэн тохиолдолд хуульд заасан бусад шийтгэл оногдуулахад саад болохгүй байхаар зохицуулав.

Мөн арваас таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт сануулах шийтгэлийг нэмж, үндсэн шийтгэлийн ангилалд хамааруулахаар тусгав.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр хуулийг 2027 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Хуулийн төсөлтэй хамт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулсан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр сануулах шийтгэл оногдуулах нөхцөл, үндэслэл хангагдсан эсэх, уг нөхцөл хангагдсан боловч өөр төрлийн шийтгэл оногдуулсан бол түүний хууль зүйн болон бодит үндэслэлийг

шийдвэрт тусгах, сануулах шийтгэл оногдуулсан тохиолдолд зөрчлийн хууль зүйн үр дагавар болон дахин зөрчил үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарлахаар тусгасан.

Харин хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн зөрчилд сануулах шийтгэл хэрэглэхгүй байх, зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, шийтгэлийн хуудасны маягт болон программ хангамжид холбогдох өөрчлөлтийг 2027 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хийж бэлэн болгохоор тусгалаа.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд шинэ байгууллага байгуулах, нэмэлт орон тоо, бүтэц бий болгох шаардлагагүй бөгөөд сануулах шийтгэлийг одоо ашиглаж байгаа мэдээллийн системд нэмэлт, өөрчлөлт хийх замаар бүртгэх боломжтой гэж үзсэн. Мөн эрх бүхий албан тушаалтны сургалт, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг холбогдох байгууллагуудын батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар тооцож, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага болон улсын төсөвт нэмэлт зардал гарахгүй гэж тооцсон.

Хуулийн төсөл батлагдсанаар хуульд заасан тодорхой төрлийн зөрчилд мөнгөн бус шийтгэл хэрэглэх эрх зүйн боломж бүрдэж, зөрчлийн шинж, нөхцөл байдал, хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх сонголт нэмэгдэнэ. Түүнчлэн зөрчил үйлдсэн этгээдэд үйлдлийнх нь хууль зүйн үр дагаврыг ойлгуулах, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгуулах, зарим тохиолдолд мөнгөн торгуулийн ачааллыг бууруулах, давтан зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн боломж бүрдэх юм.

Иймхүү Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх нь зөрчилд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай хэрэглэх, хууль сахин биелүүлэх хандлагыг төлөвшүүлэх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай уялдсан хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэж байна.

-----oOo-----

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Зөрчлийн тухай хууль анх 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан бөгөөд 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосон. Гэвч 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдөр уг хугацааг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдөр болгон хойшлуулжээ. Улмаар 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсан бөгөөд тус хуульд одоогийн байдлаар хуульд өөрчлөлт оруулсан 28, нэмэлт оруулсан 35, нэмэлт, өөрчлөлт оруулсан 29 буюу нийт 92 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуульд ийнхүү хэрэгжилтийн явцад үүссэн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн нь зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог оновчтой, үр нөлөөтэй болгох шаардлага байгааг харуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчлийн шинжийг хуулиар тодорхойлох, 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчилд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчмыг тус тус хуульчилсан. Мөн тус хуулийн 3.3 дугаар зүйлд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийн төрлийг заасан байдаг.

Практикт үйлдэгдэж буй зөрчил бүрийн шинж, нийгэмд учруулах хор уршиг ижил байдаггүй бөгөөд зарим зөрчил нь хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учруулаагүй, эсхүл нэн даруй арилгах боломжтой байдаг.

Одоогийн зохицуулалтаар зөрчилд торгох болон бусад төрлийн шийтгэл оногдуулахаар хуульчилсан боловч зөрчлийн шинж, үр дагаварт үндэслэн сануулах шийтгэл сонгох бие даасан эрх зүйн боломж бүрдээгүй байна. Иймд, хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учруулаагүй, эсхүл нэн даруй арилгах боломжтой зөрчилд торгох шийтгэлээс өөр, мөнгөн бус хариуцлагын арга хэмжээ хэрэглэх боломжийг хуульчлах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Монгол Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ)-ын 2026 оны мэдээллээр улсын хэмжээнд 65 чиг үүргийн 1102 байгууллагын 13 мянга орчим эрх бүхий алба тушаалтан жилд дөрвөн сая орчим зөрчлийг шалган шийдвэрлэдэг байна. Гэвч эрх бүхий байгууллагууд тус тусдаа мэдээллийн болон бүртгэлийн систем ашиглаж байсан нь байгууллага хооронд мэдээлэл солилцох, улсын хэмжээний статистик мэдээллийг нэгтгэн боловсруулахад хүндрэл учруулж байжээ. УЕПГ нь эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд прокурорын хяналт тавихын зэрэгцээ улсын хэмжээний зөрчлийн статистик мэдээллийг нэгтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны тогтоолын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг нэгтгэх сан байгуулах ажлыг эхлүүлж, "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-г 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлжээ. Уг сан нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, хэргийн шийдвэрлэлт, прокурорын хяналт, шүүхийн шийдвэр болон шийтгэлийн биелэлтийн мэдээллийг нэг эх үүсвэрт төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна (Монгол Улсын ерөнхий прокурорын газар, 2026).


Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн зөрчлийн тухай мэдээллийг Улсын ерөнхий прокурорын газраас 2023-2025 оны статистик мэдээлэлд Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсгээр хамгийн олон бүртгэгдсэн зөрчлүүдийн тоон үзүүлэлтийг нэгтгэн ирүүлсэн байна. Мэдээллээс үзэхэд бүртгэгдсэн зөрчлийн дийлэнх нь цөөн тооны зүйл, хэсэгт төвлөрсөн бөгөөд ялангуяа Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл 2023-2025 онд тогтмол давамгайлжээ.

Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчлийн тоо 2023 онд 2,824,162 байсан бол 2024 онд 2,882,418 болж, өмнөх оноос 58,256-аар буюу 2.1 хувиар нэмэгджээ.

Харин 2025 онд 4,503,272 зөрчил бүртгэгдсэн нь 2024 оныхоос 1,620,854-өөр буюу 56.2 хувиар өссөн байна. Ийнхүү 2023-2025 онд уг зөрчлийн тоо нийт 1,679,110-аар буюу 59.5 хувиар нэмэгдсэн бөгөөд харьцангуй тогтвортой байсан өсөлт 2025 онд огцом нэмэгджээ.

Зөрчлийн тухай хуулийн 14.7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих хэсэгт бүртгэгдсэн зөрчлийн тоон мэдээлэл, 2023-2025 он

График.1




Эх сурвалж: УЕПГ, 2026

2023-2025 онд хүн болон хуулийн этгээдэд холбогдох зөрчлийн тоо аль аль нь өссөн байна. Хүнд холбогдох зөрчил 2023 онд 3,177,838 байсан бол 2024 онд 159,947-оор буюу 5.0 хувиар нэмэгдэж, 3,337,785 болжээ. Харин 2025 онд өмнөх оноос 1,474,867-оор буюу 44.2 хувиар өсөж, 4,812,652-т хүрсэн байна. Хуулийн этгээдэд холбогдох зөрчил 2023 онд 7,528 байсан бол 2024 онд 23.5 хувиар өсөж, 9,296, улмаар 2025 онд 46.7 хувиар нэмэгдэж, 13,636 болжээ. Ийнхүү судалсан хугацаанд хүнд холбогдох зөрчил 51.4 хувиар, хуулийн этгээдэд холбогдох зөрчил 81.1 хувиар өссөн байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу бүртгэгдсэн зөрчлийн тоон мэдээлэл, хүн, хуулийн этгээд, 2023-2025 он


График.2



Эх сурвалж: УЕПГ, 2026

Хүн болон хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийн дүн 2024 онд буурч, 2025 онд өссөн байна. Хүнд оногдуулсан торгуулийн дүн 2023 онд 99,041,500,000 төгрөг байсан бол 2024 онд 13,072,806,000 төгрөгөөр буюу 13.2 хувиар буурч, 85,968,694,000 төгрөг болжээ. Харин 2025 онд өмнөх оноос 27,588,762,000 төгрөгөөр буюу 32.1 хувиар нэмэгдэж, 113,557,456,000 төгрөгт хүрсэн байна. Хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийн дүн 2024 онд 17.6 хувиар буурсан боловч 2025 онд 61,730,772,000 төгрөгөөр буюу 320.1 хувиар өсөж, 81,018,502,000 төгрөг болжээ. Ийнхүү 2023-2025 онд хүнд оногдуулсан торгуулийн дүн 14.7 хувиар, хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийн дүн 246.2 хувиар нэмэгдсэн байна. Хүнд оногдуулсан торгуулийн дүн бүх жилд давамгайлсан хэвээр боловч 2025 онд хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийн хэмжээ огцом нэмэгдсэнээр хоёр үзүүлэлтийн зөрүү мэдэгдэхүйц багасжээ.

Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хүн, хуулийн этгээдэд оногдуулсан торгуулийн дүн



Эх сурвалж: УЕПГ, 2026

Гадаад улсын эрх зүйн зохицуулалт

Гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад сануулах арга хэмжээг зөрчлийн бие даасан шийтгэл болгон хэрэглэх, торгуулийн оронд сонгон хэрэглэх, эсхүл зөрчлийг арилгах хугацаатай мэдэгдэл хүргүүлсний дараа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх зэрэг хэд хэдэн хэлбэрээр зохицуулж байна.

Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Захиргааны зөрчлийн тухай хууль (Gesetz über Ordnungswidrigkeiten — OWiG)-ийн 56 дугаар зүйлд захиргааны зөрчил ялимгүй шинжтэй тохиолдолд эрх бүхий байгууллага 5–55 еврогийн сануулах төлбөр ногдуулах, эсхүл төлбөргүйгээр сануулах боломжийг тусгасан байна. Төлбөртэй сануулгыг тухайн этгээд хүлээн зөвшөөрч, тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн тохиолдолд тухайн зөрчлийн асуудлыг эцэслэж, уг үйлдэлд дахин хариуцлага хүлээлгэхгүй байхаар зохицуулжээ. Харин сануулах арга хэмжээг бүх зөрчилд заавал эхний ээлжид хэрэглэхээр хуульчлаагүй бөгөөд эрх бүхий байгууллага зөрчлийн шинж, нөхцөл байдлыг харгалзан хэрэглэх боломжтой байна.

Харин Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №195-ФЗ Захиргааны зөрчлийн тухай кодексын 3.4 дүгээр зүйлд сануулах шийтгэлийг хувь хүн, хуулийн этгээдийг албан ёсоор буруушаасан үнэлэлт бүхий бичгээр үйлдэх захиргааны шийтгэл гэж тодорхойлжээ. Уг шийтгэлийг анх удаа үйлдсэн, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, амьтан, ургамлын аймаг, соёлын өв, улсын аюулгүй байдалд хохирол учруулаагүй, хохирол учрах аюул бий болгоогүй, мөн эд хөрөнгийн хохирол үүсгээгүй зөрчилд хуульд заасан нөхцөлийн дагуу хэрэглэхээр зохицуулсан байна. Түүнчлэн тухайн зөрчлийн зүйлд сануулах шийтгэлээр шийтгэхээр шууд заагаагүй байсан ч хуульд тогтоосон шаардлагыг хангасан тохиолдолд ногдуулах торгуулийг сануулах шийтгэлээр солих боломжийг тусгасан байна.

Франц Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн (Code du travail) L8115-1 дүгээр зүйлд хөдөлмөрийн хууль тогтоомжийн тодорхой шаардлагыг зөрчсөн ажил олгогчид сануулга өгөх, эсхүл захиргааны торгууль ногдуулах боломжийг тусгажээ. Харин L8115-4 дүгээр зүйлд эдгээр арга хэмжээг сонгохдоо зөрчлийн нөхцөл байдал, хүндийн зэрэг, зөрчил гаргагчийн зан үйл, шударга байдал, санхүүгийн эх үүсвэр болон төлбөрийн ачааллыг харгалзахаар зохицуулсан байна. Түүнчлэн L8115-5 дугаар зүйлд шийдвэр гаргахаас өмнө холбогдох этгээдэд ямар зөрчилд ямар арга хэмжээ авах гэж байгааг бичгээр мэдэгдэж, тайлбар гаргах боломж олгохоор заажээ. Энэ нь хариуцлагын арга хэмжээг зөрчлийн нөхцөл байдалд нийцүүлэн сонгох, шийдвэр гаргах ажиллагаанд тухайн этгээдийн тайлбарыг харгалзах эрх зүйн баталгаа болж байна.

Зөрчлийн тухай хуульд тусгах хэрэгцээ, шаардлага болон уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хэлбэрийн талаар иргэдийн байр суурийг тодруулах судалгааны үр дүн

Сануулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд тусгах хэрэгцээ, шаардлага болон уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хэлбэрийн талаар иргэдийн байр суурийг тодруулах зорилгоор 2026 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд цахим хэлбэрээр санал асуулга зохион байгуулж, нийт 993 иргэн оролцлоо.

Зөрчлийн тухай хуульд нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршиг учруулаагүй, эсхүл зөрчлийг даруй арилгах боломжтой тохиолдолд мөнгөн торгуулийн оронд "сануулах шийтгэл" хэрэглэх зохицуулалт бий болгох хэрэгцээ, шаардлагын талаар иргэдийн байр суурийг тодруулахад оролцогчдын 82.3 хувь нь анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчил үйлдсэн этгээдэд торгуулийн оронд сануулах шийтгэл хэрэглэх боломжийг Зөрчлийн тухай хуульд тусгахыг дэмжсэн бол 11.6 хувь нь дэмжихгүй, үлдсэн оролцогчид мэдэхгүй буюу саналгүй гэж хариулжээ.

Сануулах шийтгэлийг хэрэглэх нөхцөлийн тухайд оролцогчдын 65.5 хувь нь анх удаа зөрчил үйлдсэн, 49.2 хувь нь хохирол, хор уршиг учруулаагүй, 45.5 хувь нь санаатай бус зөрчил үйлдсэн, 36.4 хувь нь зөрчлийг нэн даруй арилгасан тохиолдолд сануулах шийтгэл хэрэглэхийг дэмжсэн байна.

Сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн төрлийн хувьд оролцогчдын 60.3 хувь нь замын хөдөлгөөний бага зэргийн зөрчил, 43.6 хувь нь төрийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг анх удаа зөрчсөн тохиолдол, 42.7 хувь нь татвар, төлбөртэй холбоотой бага зэргийн зөрчилд хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн байна. Харин 11.1 хувь нь ямар ч зөрчилд сануулах шийтгэл хэрэглэхгүй байх байр суурь илэрхийлжээ.

Сануулах шийтгэлийг хэрэглэх давтамжийн тухайд оролцогчдын 44.6 хувь нь нэг удаа хэрэглэх нь зохистой гэж үзсэн бол 19.5 хувь нь зөрчлийн төрлөөс хамааруулах, 18 хувь нь гурав хүртэл удаа, 16.7 хувь нь хоёр удаа хэрэглэхийг дэмжсэн байна.

Хэрэгжүүлэх хэлбэрийн тухайд оролцогчдын 20 хувь нь зөрчлийг арилгах хугацаа олгох, 19.4 хувь нь дээрх аргуудыг хослуулах, 18.2 хувь нь цахим хэлбэрээр бүртгэж сануулах, 16.9 хувь нь бичгээр сануулах, 13.8 хувь нь хуулийн хариуцлагын талаар тайлбарлаж сануулах, 11.7 хувь нь зөвхөн амаар сануулах хувилбарыг сонгожээ.

Сануулах шийтгэлийг хэрэглэх давтамжийн тухайд оролцогчдын 44.2 хувь нь нэг удаа хэрэглэх нь зохистой гэж үзсэн бол 19.8 хувь нь зөрчлийн төрлөөс хамааруулах, 17.9 хувь нь гурав хүртэл удаа, 16.9 хувь нь хоёр удаа хэрэглэхийг дэмжсэн байна.

Хэрэгжүүлэх хэлбэрийн тухайд оролцогчдын 20.6 хувь нь зөрчлийг арилгах хугацаа олгох, 19 хувь нь дээрх аргуудыг хослуулах, 18.4 хувь нь цахим хэлбэрээр бүртгэж сануулах, 16.1 хувь нь бичгээр сануулах, 13.5 хувь нь хуулийн хариуцлагын талаар тайлбарлаж сануулах, 12.3 хувь нь зөвхөн амаар сануулах хувилбарыг сонгожээ.

Иймд иргэдийн санал асуулгын үр дүн, холбогдох судалгаа, эрх зүйн зохицуулалтад үндэслэн зөрчлийг анх удаа үйлдсэн, хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учруулаагүй, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд зөрчлийн үр дагаврыг сайн дураар, нэн даруй арилгасан тохиолдолд сануулах шийтгэл хэрэглэх эрх зүйн үндэслэл, нөхцөл, журмыг тодорхой болгох зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төслийн хүрээнд зөрчил гаргасан этгээдэд тухайн зөрчлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлаж, дахин зөрчил гаргахгүй байхыг анхааруулсан мэдэгдэл хүргүүлэх замаар **"сануулах шийтгэл"**-ийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хуульчлах, түүнийг хэрэглэх үндэслэл, нөхцөл, журмыг тодорхойлохоор тусгасан.

Нэр томьёоны тухайд:

"Сануулах шийтгэл" нь зөрчил гаргасан этгээдэд хуулиар хүлээсэн үүрэг, зөрчил гаргасны эрх зүйн үр дагаврыг тайлбарлан ойлгуулж, дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготой шийтгэлийг илэрхийлнэ. Энэхүү зохицуулалт нь зөрчил гаргасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөх бус, харин зөрчлийн шинж, учруулсан хор уршиг, зөрчлийг арилгасан нөхцөл байдалд нийцүүлэн мөнгөн торгуулийн оронд сануулах шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Сануулах шийтгэлийг бүх төрлийн зөрчилд хамааруулахгүй бөгөөд зөвхөн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид сануулах шийтгэл оногдуулж болохоор заасан тохиолдолд хэрэглэхээр тусгав. Мөн сануулах шийтгэлийг цаасан болон цахим хэлбэрээр оногдуулж, зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэхээр зохицуулсан нь шийтгэлийн хэрэгжилтийг баримтжуулах, бүртгэлд үндэслэн зөрчил дахин үйлдсэн эсэхийг тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ач холбогдолтой.

Хуулийн төсөлд сануулах шийтгэл хэрэглэхдээ зөрчил анх удаа үйлдсэн эсэх, хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол, хор уршиг учирсан эсэх, зөрчлийн үр дагаврыг сайн дураар, нэн даруй арилгасан эсэхийг

харгалзан үзэхээр тусгав. Эдгээр нөхцөл нь сануулах шийтгэлийг үндэслэлтэй, зөрчлийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэхэд чиглэнэ.

Нэгдүгээр зүйл. Сануулах шийтгэлийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сануулах шийтгэлийг шийтгэлийн төрөл болгон нэмж, 3.11 дүгээр зүйлд сануулах шийтгэлийн ойлголт, хэрэглэх нөхцөл, хэлбэр, бүртгэл, оногдуулах журмыг тусгасан.

Сануулах шийтгэлийг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэх бөгөөд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэхээр зохицуулсан. Түүнчлэн сануулах шийтгэлийг сонгон оногдуулахаар заасан зөрчилд бусад шийтгэл оногдуулахгүйгээр эхний ээлжид сануулах шийтгэлийг сонгохоор тусгасан нь зөрчилд шаталсан, тохирсон хариу арга хэмжээ хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Мөн сануулах шийтгэлийг арван нэгжээс таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд хэрэглэхээр хязгаарласан нь уг шийтгэлийг харьцангуй бага хэмжээний торгуультай зөрчилд хэрэглэх эрх зүйн хүрээг тогтоож байна.

Хоёрдугаар зүйл. Шийтгэлийн төрөлд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийтгэлийн төрөлд холбогдох зохицуулалтад "сануулах" гэдэг үгийг нэмэхээр тусгав.

Ингэснээр сануулах шийтгэлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хуульд заасан бусад шийтгэлийн нэгэн адил хэрэглэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

Гуравдугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр хуулийг 2027 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан. Энэ нь хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах, эрх бүхий албан тушаалтны ажиллагаа, зөрчлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэл болон холбогдох журмыг шинэ зохицуулалтад нийцүүлэх хугацаа олгох зорилготой.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр сануулах шийтгэлийг хэрэглэхтэй холбоотой процессын зохицуулалтыг тусгасан.

Тухайлбал, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сануулах шийтгэл оногдуулах нөхцөл, үндэслэл хангагдсан эсэхийг шалгах, уг нөхцөл, үндэслэл хангагдсан боловч сануулах шийтгэл оногдуулахгүйгээр өөр төрлийн шийтгэл оногдуулж байгаа бол түүний хууль зүйн болон бодит үндэслэлийг шийдвэрт тусгахаар зохицуулсан.

Мөн сануулах шийтгэл оногдуулсан бол шийдвэрт тухайн шийтгэлийн хууль зүйн болон бодит үндэслэл, зөрчлийн хууль зүйн үр дагавар, дахин зөрчил үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарлахаар тусгасан. Энэ нь сануулах шийтгэлийг

үндэслэлтэй хэрэглэх, зөрчил гаргасан этгээдэд хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагыг ойлгуулахад чиглэнэ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

Хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр шинэ зохицуулалт хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн зөрчилд сануулах шийтгэл хэрэглэхгүй байхаар тусгасан.

Түүнчлэн сануулах шийтгэлийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах хүрээнд зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, шийтгэлийн хуудасны маягт, программ хангамжид холбогдох өөрчлөлтийг 2027 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө хийж, бэлэн болгохоор зохицуулсан. Ингэснээр шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн болон техникийн бэлтгэлийг хангах юм.

-----oOo-----

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД САНУУЛАХ ШИЙТГЭЛИЙГ БИЙ БОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА

Улаанбаатар хот

2026 он

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1 Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох
1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох
1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

1.4 Иргэдээс авсан санал асуулгын үр дүн

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

3.1. Шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу "тэг" хувилбар

3.2. Олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар

3.3. Захиргааны шийдвэр гаргах, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар

3.4. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах буюу сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбар

3.5. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ

3.6. Дүгнэлт

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
4.4. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

5.1. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт
5.2. Гарч болох эерэг үр дүн
5.3. Гарч болох сөрөг үр дагавар
5.4. Харьцуулсан дүгнэлт

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

6.1. Судалгааны зорилго, хамрах хүрээ
6.2. Гадаад улсын эрх зүйн зохицуулалт
6.3. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд тусгах боломж
6.4. Дүгнэлт

ДОЛОО. ДҮГНЭЛТ, НОМ ЗҮЙ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад зөрчилд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд Зөрчлийн тухай хуулийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр баталсан. Улмаар уг хуулийг дагаж мөрдөх хугацааг хойшлуулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр шинэчилсэн найруулгыг батлан, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлсэн байна.

Зөрчлийн тухай хуулиар зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдэхүй, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээ, хариуцлага хүлээлгэх үндсэн зарчмыг хуульчлан тогтоосон. Тус хуулийн 3.3 дугаар зүйлд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийг хуульчилсан боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон тусгаагүй байна. Хуулийн хэрэгжилтийн явцад зарим зөрчлийн бүрэлдэхүүний тодорхой байдал, зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон шийтгэл хэрэглэх боломж, торгох шийтгэлийн биелэлт болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй холбоотой асуудал хөндөгдөж иржээ.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгуулах боломжийг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгаж байсан боловч уг төсөл эцэслэн батлагдаагүй байна.[1]

Сануулах шийтгэлийг нэвтрүүлэх асуудал нь зөвхөн шийтгэлийн шинэ төрөл бий болгохоор хязгаарлагдахгүй. Тухайлбал, уг шийтгэлийг хэрэглэх зөрчлийн хүрээ, үндэслэл, нөхцөл, шалгуур, эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах ажиллагаа, бүртгэл, хяналт, давтан зөрчлийн эрх зүйн үр дагавар болон бусад хууль тогтоомжтой уялдах байдлыг хамтад нь авч үзэх шаардлагатай.

Мөн сануулах шийтгэлийг төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлдэг зөвлөн туслах, урьдчилан сануулах, албан шаардлага өгөх арга хэмжээнээс ялгах нь зүйтэй. Сануулах шийтгэл нь зөрчил үйлдсэн нь тогтоогдсон этгээдэд хууль заасан үндэслэлээр оногдуулах хариуцлагын төрөл байх бол хяналт шалгалтын хүрээний зөвлөн туслах болон албан шаардлага нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахад чиглэнэ.

Энэхүү тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын хүрээнд боловсруулж, асуудлын мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, зохицуулалтын боломжит хувилбаруудыг харьцуулах,

[1] Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 14-нд өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.

тэдгээрийн үр нөлөөг урьдчилан үнэлэх, хэрэгжүүлэх боломжтой хувилбарыг сонгон зөвлөмж боловсруулахад чиглүүлэв.

Судалгаанд хүчин төгөлдөр хууль тогтоомж, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн судалгаа, эрх бүхий байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн статистик болон хэрэгжилтийн мэдээлэл, иргэдийн цахим санал асуулга, өмнөх хуулийн төслүүд, гадаад улсын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн үр нөлөөний холбогдох судалгааг ашигласан болно.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох

Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийн төрлийг хуульчилсан боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон тусгаагүй байна.[2] Энэ нь хуульд заасан тодорхой төрлийн зөрчилд тухайн үйлдлийн шинж, нөхцөл байдал, бодит болон болзошгүй хор уршгийг харгалзан торгохоос өөр мөнгөн бус хариуцлага хүлээлгэх эрх зүйн боломжийг хязгаарлаж байна.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгаанд зөрчлийн зарим бүрэлдэхүүнийг ерөнхий байдлаар тодорхойлсон, зөрчлийн шинж, учруулсан хохирол, хор уршиг харилцан адилгүй боловч торгох шийтгэл оногдуулах нөхцөл бүрддэг талаар тэмдэглэжээ. Иймээс зөрчлийн бүрэлдэхүүнийг тодорхой болгох асуудлаас гадна зөрчилд оногдуулах шийтгэлийн төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага хөндөгдөж байна.

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс 2026 онд боловсруулсан "Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж" судалгаанд Зөрчлийн тухай хуулийн 1,979 зохицуулалтыг шийтгэлийн төрөл, хэлбэрээр ангилан шинжилжээ. Судалгааны үр дүнгээр 1,062 буюу 53.7 хувьд зөвхөн торгох шийтгэл, 900 буюу 45.5 хувьд торгох шийтгэлийг бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр заасан байна. Ийнхүү судалгаанд хамрагдсан зохицуулалтын 99.1 хувьд торгох шийтгэлийг дангаар буюу бусад арга хэмжээтэй хослуулан хэрэглэхээр хуульчилсан нь торгох шийтгэл эрх зүйн зохицуулалтад давамгайлж байгааг харуулж байна.[3]

Сануулах шийтгэл хэрэглэх боломжтой зөрчлийн хүрээг тодорхойлохдоо тухайн зөрчлийн бүрэлдэхүүн, хамгаалж буй эрх, хууль ёсны ашиг сонирхол, зөрчлийн шинж, учруулсан болон учруулж болзошгүй хохирол, хор уршиг, анх удаа эсхүл давтан үйлдсэн байдал, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгах боломжийг харгалзан үзэх шаардлагатай.

---

[2] Зөрчлийн тухай хууль, 3.3 дугаар зүйл.

[3] Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, 2026 он.

Тухайлбал, нийгмийн хор уршиг багатай, бодит хохирол учруулаагүй, эсхүл зөрчлийн үр дагаврыг богино хугацаанд арилгах боломжтой зарим зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх эсэхийг судлах үндэслэлтэй байна.

Харин хүний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн эрх, нийтийн аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд бодит хохирол, өндөр эрсдэл учруулсан, санаатай болон давтан үйлдсэн, хууль бус ашиг олох зорилготой зөрчилд уг шийтгэлийг хэрэглэх боломж, хязгаарлалтыг тусгайлан үнэлэх нь зүйтэй.

Иймд асуудлын мөн чанар нь торгох шийтгэл давамгайлсан эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөрчлийн шинж, нөхцөл байдал, хохирол, хор уршигт тохирсон хариуцлагыг ялгамжтай хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагаар тодорхойлогдож байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох

Сануулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх асуудал нь зөрчлийн хариуцлага хүлээх хүн, хуулийн этгээд, зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй этгээд, түүнчлэн уг зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлнө.

Нэгдүгээрт, зөрчлийн хариуцлага хүлээх иргэд уг зохицуулалтын шууд нөлөөлөлд өртөх үндсэн бүлэг болно. Тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн хэв журам, орчны цэвэрлэгээ, хог хаягдал болон өдөр тутмын амьдралтай холбоотой хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн иргэдийн үйлдэлд сануулах шийтгэл хэрэглэх боломжийг тухайн зөрчлийн шинж, хор уршгаас хамааран судалж болно.

Сануулах шийтгэлийг хуульд тусгайлан заасан нөхцөлөөр хэрэглэх зохицуулалт бий болсон тохиолдолд иргэдэд торгох шийтгэлийн оронд мөнгөн бус хариуцлага хүлээх, тухайн үйлдлийн хууль зүйн үр дагаврыг ойлгох, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгах боломж бүрдэж болох юм. Гэхдээ шийтгэл хэрэглэх үндэслэл, нөхцөл, шалгуурыг тодорхой хуульчлахгүй бол ижил шинжтэй зөрчилд ялгаатай шийдвэр гаргах, эрх бүхий албан тушаалтны үзэмжээр шийтгэл оногдуулах эрсдэл үүсэж болзошгүй.

Хоёрдугаарт, сануулах шийтгэл нэвтрүүлэх асуудал нь Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээд, түүний дотор аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой. Зарим төрлийн зөрчил нь хуульд заасан үүргийг биелүүлээгүй, баримт бичиг бүрдүүлээгүй, тайлагнах болон зохион байгуулалтын шинжтэй шаардлага зөрчсөн хэлбэрээр илэрч болно.

Гэвч хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой бүх зөрчлийг хор уршиг багатай гэж үзэх боломжгүй. Иймд хуулийн этгээдэд сануулах шийтгэл хэрэглэх

нөхцөлийг тодорхойлохдоо зөрчлийн шинж, учруулсан хохирол, хор уршиг, хууль бус ашиг олсон эсэх, давтан үйлдсэн байдал болон зөрчлийг сайн дураар арилгасан эсэхийг харгалзан үзэх шаардлагатай.

Гуравдугаарт, сануулах шийтгэл нэвтрүүлэх асуудлыг судлахад зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй этгээдийн эрхийг хамгаалах асуудал чухал байр суурь эзэлнэ.

Тухайлбал, хүний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн эрх, хэрэглэгчийн эрх ашиг, нийтийн аюулгүй байдал болон хүрээлэн буй орчинд бодит хохирол, өндөр эрсдэл учруулсан зөрчилд сануулах шийтгэлийг хэрэглэх хүрээг тогтоохдоо тухайн зөрчлийн хамгаалж буй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлагатай.

Иймд сануулах шийтгэл нэвтрүүлэх нь зөрчлийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хамгаалах зохицуулалтыг сулруулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх болон зөрчлийн үр дагаврыг арилгуулах үүргийг хөнгөрүүлэх үндэслэл болохгүй байх ёстой.

Дөрөвдүгээрт, сануулах шийтгэл нэвтрүүлэх нь зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүрэг болон үйл ажиллагааны зохион байгуулалтад нөлөөлнө. Тухайлбал, сануулах шийтгэл хэрэглэх үндэслэл, нөхцөлийг шалгаж тогтоох, шийдвэр гаргах, шийдвэрийг бүртгэх, биелэлтэд хяналт тавих, давтан үйлдлийг тогтоох болон шийдвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаатай уялдуулах шаардлага үүснэ.

Иймд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагыг үнэлэхдээ хариуцлага хүлээх хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, зөрчлийн улмаас хохирч болзошгүй бусад этгээдийн эрх болон зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагын чиг үүргийг харилцан тэнцвэртэй авч үзэх нь зүйтэй байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөл

Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх асуудал нь зөрчилд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалтын бүтэц, шийтгэлийн төрөл, зөрчлийн бүрэлдэхүүний тодорхой байдал, хууль хэрэглээний практик, торгох шийтгэлийн биелэлт болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой байна.

Нэгдүгээрт, торгох шийтгэл эрх зүйн зохицуулалтад давамгайлж байгаа нөхцөл байдал.

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2026 оны судалгаагаар Зөрчлийн тухай хуулийн 1,979 зохицуулалтын 1,062 буюу 53.7 хувьд зөвхөн торгох шийтгэл, 900 буюу 45.5 хувьд торгох шийтгэлийг бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр заасан байна.

Иймд нийгмийн хор уршиг багатай, бодит хохирол учруулаагүй, эсхүл зөрчлийн үр дагаврыг богино хугацаанд арилгах боломжтой зарим зөрчилд торгохоос өөр мөнгөн бус шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэв.

Хоёрдугаарт, зөрчлийн зарим бүрэлдэхүүний ерөнхий зохицуулалт.

Зөрчлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэгт хуульд заасан үүргээ биелүүлээгүй, журам зөрчсөн, хуулиар хориглосон үйлдэл гаргасан гэх зэрэг ерөнхий томьёолол хэрэглэснээр харилцан адилгүй шинж, хор уршигтай үйлдлийг нэг зохицуулалтад хамруулах нөхцөл үүсэж болох юм.

Иймд зөрчлийн бүрэлдэхүүнийг тодорхой болгохын зэрэгцээ тухайн зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон шийтгэл хэрэглэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Гэвч зөрчлийн бүрэлдэхүүний ерөнхий томьёоллоос үүсэх асуудлыг зөвхөн санууулах шийтгэл нэвтрүүлэх замаар бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд зөрчилд тооцох үйлдлийн хүрээ, бүрэлдэхүүний шинжийг боловсронгуй болгох асуудлыг хамтад нь авч үзнэ.

Гуравдугаарт, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн хэмжээ болон торгуулийн биелэлттэй холбсотой нөхцөл байдал.

Судалгаанд ашигласан Улсын ерөнхий прокурорын газар болон холбогдох байгууллагын мэдээлэлд дурдсанаар 2021–2025 онд нийт 16,064,538 зөрчил прокурорын хяналтад хамрагдаж, шийтгэл оногдуулсан тухай мэдээлэл тусгагдсан байна.[4] Мөн 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4,353,418 зөрчил бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өссөн гэж мэдээлжээ.[5]

Түүнчлэн 2026 оны эхний хагас жилийн байдлаар хүн, хуулийн этгээдэд нийт 114.3 тэрбум төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, үүнээс 58.3 тэрбум төгрөг буюу 51.0 хувь нь төлөгдсөн тухай мэдээлэл судалгаанд тусгагдсан байна.[6]

Эдгээр статистик мэдээлэл нь зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн хэмжээ, торгох шийтгэлийн биелэлт болон зөрчлийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох үндэслэл болж байна.

Дөрөвдүгээрт, зөрчлийн шинж, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх хэрэгцээ, шаардлага.

Зөрчилд хүлээлгэх хариуцлага нь тухайн үйлдлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршиг болон хамгаалж буй эрх, хууль ёсны ашиг сонирхолтой зохистой харьцаатай байх шаардлагатай.

---

[4] Улсын ерөнхий прокурорын газрын статистик мэдээлэл.

[5] Улсын ерөнхий прокурорын газрын 2026 оны эхний хагас жилийн статистик мэдээлэл.

[6] Торгуулийн биелэлтийн талаарх холбогдох байгууллагын статистик мэдээлэл.

Энэ хүрээнд зөрчлийг анх удаа эсхүл давтан үйлдсэн байдал, бодит хохирол учруулсан эсэх, хохирол учрах аюул бий болгосон эсэх, зөрчлийг сайн дураар арилгасан байдал, зөрчил үйлдсэн этгээдийн авсан арга хэмжээ зэрэг нөхцөлийг харгалзан үзэх шаардлагатай.

Тавдугаарт, төрийн хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх чиг үүргийн уялдаа.

Зөрчлийг илрүүлж шийтгэл оногдуулах ажиллагаанаас гадна хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг сайн дураар арилгуулах арга хэмжээг хариуцлагын тогтолцоотой уялдуулах шаардлага байна.

Гэхдээ төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлдэг зөвлөн туслах, урьдчилан сануулах, албан шаардлага өгөх арга хэмжээ нь Зөрчлийн тухай хуулиар оногдуулах сануулах шийтгэлээс эрх зүйн үндэслэл, зорилго, үр дагаврын хувьд ялгаатай тул тэдгээрийг тусад нь зохицуулах шаардлагатай.

Зургаадугаарт, сануулах шийтгэл хэрэглэх эрх зүйн механизм бүрдээгүй байдал.

Хүчин төгөлдөр Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хуульчлаагүй тул түүнийг хэрэглэх зөрчлийн хүрээ, үндэслэл, нөхцөл, шалгуур, шийдвэр гаргах журам, бүртгэл, хяналт болон давтан үйлдлийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлох шаардлага үүсэж байна.

Энэ нь сануулах шийтгэлийг зөвхөн шийтгэлийн төрөлд нэр төдий нэмэх бус, хэрэгжүүлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатайг харуулж байна.

Дээрх шалтгаан, нөхцөлийг нэгтгэн үзэхэд Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх асуудал нь торгох шийтгэл давамгайлсан зохицуулалт, зөрчлийн зарим бүрэлдэхүүний тодорхой бус байдал, шийтгэлийн биелэлт, хариуцлагыг ялгамжтай хэрэглэх хэрэгцээ, төрийн хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх чиг үүргийн уялдаа болон шинэ шийтгэлийн төрөл хэрэглэх эрх зүйн механизм бүрдээгүй байдалтай холбогдож байна.

Иймд сануулах шийтгэлийг бүх төрлийн зөрчилд нийтлэг хэрэглэх бус, нийгмийн хор уршиг багатай, хуульд тусгайлан заасан тодорхой төрлийн зөрчилд хэрэглэх нөхцөл, шалгуур, хязгаарлалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзэв.

1.4. Иргэдээс авсан санал асуулгын үр дүн

Сануулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд тусгах хэрэгцээ, шаардлага болон үг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хэлбэрийн талаар иргэдийн байр суурийг

тодруулах зорилгоор 2026 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд цахим хэлбэрээр санал асуулга зохион байгуулж, нийт 993 иргэн оролцов.

1.4.1 Судалгааны зорилго, арга зүй

Энэхүү судалгааны зорилго нь хор аюул багатай, зөрчлийн хор уршгийг шууд учруулаагүй, эсхүл даруй арилгах боломжтой зөрчлүүдэд сануулах шийтгэлийг оногдуулах зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд тусгах хэрэгцээ, шаардлагын талаар иргэдийн байр суурийг тодруулж, уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хамруулах зөрчлийн төрөл, хэрэгжүүлэх хэлбэрийн талаарх саналыг нэгтгэн судлахад оршино.

Санал асуулгыг цахим хэлбэрээр явуулсан бөгөөд нийт 11 асуултаар оролцогчдын нас, оршин суугаа газар, ажил эрхлэлтийн байдал, Зөрчлийн тухай хуулийн талаарх мэдээлэлтэй байдал, өмнө нь зөрчлийн шийтгэл хүлээсэн эсэх, нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршгийг шууд учруулаагүй, эсхүл даруй арилгах боломжтой зөрчил үйлдсэн этгээдэд мөнгөн торгуулийн оронд сануулах шийтгэл хэрэглэх зохицуулалтыг дэмжиж байгаа эсэх, түүнийг хэрэглэх нөхцөл, хамруулах зөрчлийн төрөл, хэрэгжүүлэх хэлбэрийн талаарх саналыг авав.

Судалгаанд иргэд сайн дурын үндсэн дээр оролцсон бөгөөд нийт хүн амыг төлөөлөх магадлалт түүврийн судалгаа биш юм. Иймд санал асуулгын үр дүнг сануулах шийтгэлийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход харгалзах нэмэлт мэдээллийн эх сурвалж болгон ашиглаж, холбогдох хууль тогтоомжийн шинжилгээ, статистик мэдээлэл болон бусад судалгааны үр дүнтэй хамтатган үнэлэв.

1.4.2 Судалгааны асуулт

1. Таны нас
    - 18-25 нас
    - 26-35 нас
    - 36-45 нас
    - 46-55 нас
    - 56-аас дээш
2. Таны оршин суугаа газар
    - Улаанбаатар
    - Аймгийн төв
    - Сум
    - Бусад
3. Таны ажил эрхлэлтийн байдал
    - Оюутан
    - Албан хаагч
    - Хувиараа аж ахуй эрхлэгч
    - Тэтгэвэр авагч
    - Бусад

4. Зөрчлийн тухай хуулиар зөрчил гаргасан тохиолдолд торгууль ногдуулдаг талаар хэр мэдээлэлтэй вэ?
   - Маш сайн мэднэ
   - Мэднэ
   - Бага зэрэг мэднэ
   - Мэдэхгүй
5. Та өмнө нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл хүлээж байсан уу?
   - Тийм
   - Үгүй
6. Таны бодлоор бага хэмжээний, анх удаа үйлдсэн зөрчилд шууд мөнгөн торгууль ногдуулах нь хэр зохистой вэ?
   - Маш зохистой
   - Зохистой
   - Зарим тохиолдолд зохистой
   - Зохисгүй
   - Огт зохисгүй
7. Анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчил үйлдсэн этгээдэд торгуулийн оронд "сануулах шийтгэл" хэрэглэх боломжийг Зөрчлийн тухай хуульд бий болгохыг та дэмжиж байна уу?
   - Дэмжиж байна
   - Дэмжихгүй байна
   - Мэдэхгүй / саналгүй
8. Сануулах шийтгэлийг ямар тохиолдолд хэрэглэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ? */Олон хариулт сонгож болно./*
   - Анх удаа зөрчил үйлдсэн
   - Хохирол, хор уршиг учруулаагүй
   - Бага хэмжээний хохирол учруулсан
   - Зөрчлийг нэн даруй арилгасан
   - Санаатай бус зөрчил үйлдсэн
   - Бусад
9. Сануулах шийтгэлийг ямар зөрчилд хэрэглэх нь зүйтэй вэ? */Олон хариулт сонгож болно /*
   - Замын хөдөлгөөний бага зэргийн зөрчил
   - Худалдаа, үйлчилгээний журмын бага зэргийн зөрчил
   - Татвар, төлбөртэй холбоотой бага зэргийн зөрчил
   - Ариун цэвэр, эрүүл ахуйн бага зэргийн зөрчил
   - Байгаль орчны бага зэргийн зөрчил
   - Төрийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг анх удаа зөрчсөн тохиолдол
   - Ямар ч зөрчилд хэрэглэхгүй байх
   - Бусад
10. Сануулах шийтгэлийг хэдэн удаа хэрэглэх нь зохистой гэж та үзэж байна вэ?
    - Нэг удаа
    - Хоёр удаа
    - Гурав хүртэл удаа
    - Хязгааргүй

- Зөрчлийн төрлөөс хамаарна

11. "Сануулах шийтгэл"-ийг хэрхэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?
    - Зөвхөн амаар сануулах
    - Бичгээр сануулах
    - Цахим хэлбэрээр бүртгэж сануулах
    - Зөрчлийг арилгах хугацаа олгох
    - Хуулийн хариуцлагын талаар тайлбарлаж, сануулах
    - Дээрхийг хослуулах

1.4.3 Судалгааны үр дүн

1.Оролцогчдын ерөнхий мэдээлэл

Санал асуулгад оролцогчдын 8 хувь нь 18-25 настай, 23.3 хувь нь 26-35 настай, 33.7 хувь нь 36-45 настай, 27.6 хувь нь 46-55 настай, 7.4 хувь нь 56-аас дээш настай байв. Оролцогчдын 91 1 хувь нь Улаанбаатар хотод, 4.6 хувь нь аймгийн төвд, 3.7 хувь нь суманд оршин суудаг. Ажил эрхлэлтийн хувьд төрийн албан хаагч 76.2 хувь, хувиараа аж ахуй эрхлэгч 11.1 хувь, ААН, хуулийн этгээдийн төлөөлөгч 7.9 хувийг тус тус бүрдүүлжээ

График 1. Оролцогчдын насны бүтэц




График 2. Оролцогчдын оршин суугаа газар





График 3. Оролцогчдын ажил эрхлэлтийн байдал



2. Зөрчлийн тухай хуулийн талаарх мэдлэг, туршлага

Зөрчил гаргасан тохиолдолд торгууль ногдуулдаг талаар оролцогчдын 43.6 хувь нь мэднэ, 38 хувь нь бага зэрэг мэднэ, 11.3 хувь нь маш сайн мэднэ гэж хариулсан бол 7.1 хувь нь мэдэхгүй гэжээ. Оролцогчдын 22.4 хувь нь өмнө нь Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл хүлээж байсан, 77.6 хувь нь шийтгэл хүлээж байгаагүй байна.

График 4. Торгууль ногдуулдаг талаар мэдээлэлтэй байдал






График 5. Өмнө нь шийтгэл хүлээж байсан эсэх



3. Торгуулийн зохистой байдал

Анх удаа, бага хэмжээний зөрчилд шууд мөнгөн торгууль ногдуулах нь зохисгүй гэж 38.3 хувь нь, огт зохисгүй гэж 17.8 хувь нь үзсэн нь нийт оролцогчдын 56.1 хувь болж байна. Зарим тохиолдолд зохистой гэж 34 хувь нь, зохистой болон маш зохистой гэж 9.8 хувь нь хариулсан.


График 6. Анх удаа, бага хэмжээний зөрчилд шууд мөнгөн торгууль ногдуулах нь хэр зохистой вэ?



4. Сануулах шийтгэлийг хуульд тусгах хэрэгцээ, шаардлага

Зөрчлийн тухай хуульд нийгмийн хор аюул багатай, зөрчлийн хор уршиг учруулаагүй, эсхүл зөрчлийг даруй арилгах боломжтой тохиолдолд мөнгөн торгуулийн оронд "сануулах шийтгэл" хэрэглэх зохицуулалт бий болгох хэрэгцээ, шаардлагын талаар иргэдийн байр суурийг тодруулахад оролцогчдын 82.3 хувь нь анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчил үйлдсэн этгээдэд торгуулийн оронд сануулах шийтгэл хэрэглэх боломжийг Зөрчлийн тухай хуульд тусгахыг дэмжсэн бол 11.6 хувь нь дэмжихгүй, үлдсэн оролцогчид мэдэхгүй буюу саналгүй гэж хариулжээ.


График 7. Сануулах шийтгэлийг хуульд тусгахыг дэмжих байдал



5. Сануулах шийтгэл хэрэглэх нөхцөл

Сануулах шийтгэлийг хэрэглэх нөхцөлийн тухайд оролцогчдын 65.5 хувь нь анх удаа зөрчил үйлдсэн, 49.2 хувь нь хохирол, хор уршиг учруулаагүй, 45.5 хувь нь санаатай бус зөрчил үйлдсэн, 36.4 хувь нь зөрчлийг нэн даруй арилгасан тохиолдолд сануулах шийтгэл хэрэглэхийг дэмжсэн байна.


График 8. Сануулах шийтгэл хэрэглэх нөхцөл (олон хариулт сонгох боломжтой)



6. Сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн төрөл

Сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн төрлийн хувьд оролцогчдын 60.3 хувь нь замын хөдөлгөөний бага зэргийн зөрчил, 43.6 хувь нь төрийн байгууллагаас тавьсан хууль ёсны шаардлагыг анх удаа зөрчсөн тохиолдол, 42.7 хувь нь татвар, төлбөртэй холбоотой бага зэргийн зөрчилд хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн байна. Харин 11.1 хувь нь ямар ч зөрчилд сануулах шийтгэл хэрэглэхгүй байх байр суурь илэрхийлжээ.


График 9. Сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн төрөл (олон хариулт сонгох боломжтой)



7. Сануулах шийтгэл хэрэглэх давтамж

Сануулах шийтгэлийг хэрэглэх давтамжийн тухайд оролцогчдын 44.6 хувь нь нэг удаа хэрэглэх нь зохистой гэж үзсэн бол 19.5 хувь нь зөрчлийн төрлөөс хамааруулах, 18 хувь нь гурав хүртэл удаа, 16.7 хувь нь хоёр удаа хэрэглэхийг дэмжсэн байна.


Зураг 10. Сануулах шийтгэл хэрэглэх давтамж



8. Сануулах шийтгэлийг хэрэгжүүлэх үелбэр

Хэрэгжүүлэх хэлбэрийн тухайд оролцогчдын 20 хувь нь зөрчлийг арилгах хугацаа олгох, 19.4 хувь нь дээрх аргуудыг хослуулах, 18.2 хувь нь цахим хэлбэрээр бүртгэж сануулах, 16.9 хувь нь бичгээр сануулах, 13.8 хувь нь хуулийн хариуцлагын талаар тайлбарлаж сануулах, 11.7 хувь нь зөвхөн амаар сануулах хувилбарыг сонгожээ.

Зураг 11. Сануулах шийтгэлийг хэрэгжүүлэх хэлбэр



ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Өмнөх шатанд хийсэн дүн шинжилгээгээр Зөрчлийн тухай хуульд торгох шийтгэл давамгайлсан зохицуулалттай зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт нийцүүлэн хариуцлагыг ялгамжтай хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг тодорхойлсон.

Иймд асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлов.

Ерөнхий зорилго: Зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлагын арга хэмжээг ялгамжтай, шаталсан байдлаар хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлж, зөрчлийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

Энэхүү зорилгод хүрэх боломжит арга замын нэг нь Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлж, зөвхөн хуульд тусгайлан заасан тодорхой төрлийн зөрчилд хэрэглэх нөхцөл, шалгуур, хязгаарлалт болон эрх зүйн үр дагаврыг тодорхойлох явдал юм.

Ерөнхий зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах тусгай зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн төрөл, хэмжээ, хууль хэрэглээний практикт үүсэж буй хүндрэл, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
2. Сануулах шийтгэл хэрэглэх боломжтой зөрчлийн төрөл, хамрах хүрээ, үндэслэл, нөхцөл, шалгуур болон хэрэглэхгүй байх хязгаарлалтыг тогтоох боломжийг судлах
3. Сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх болон асуудлыг шийдвэрлэх бусад боломжит хувилбаруудыг харьцуулан үнэлэх;
4. Сануулах шийтгэл оногдуулах эрх бүхий субъект, шийдвэр гаргах, бүртгэх, хяналт тавих давтан үйлдлийн эрх зүйн үр дагаврыг зохицуулах эрх зүйн болон зохион байгуулалтын нөхцөлийг тодорхойлох;
5. Зохицуулалтын боломжит хувилбаруудын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон хууль зүйн үр нөлөө, хэрэгжүүлэх зардал, үр өгөөжийг харьцуулан үнэлэх;
6. Сануулах шийтгэл нэвтрүүлэх тохиолдолд хэрэгжилтийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт хяналт-шинжилгээний боломжийг тодорхойлох.

Зорилтын хэрэгжилтийг үнэлэхдээ сануулах шийтгэл хэрэглэх эрх зүйн боломж бүрдсэн эсэх тухайн шийтгэлийг хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуур тодорхой болсон эсэх, шийдвэрийн бүртгэл, хяналтын тогтолцоо бүрдсэн эсэхийг эрх зүйн зохицуулалтын түвшинд авч үзэж болно.

Харин хэрэгжилтийн бодит үр нөлөөг сануулах шийтгэл оногдуулсан тохиолдлын тоо, зөрчлийн үр дагаврыг сайн дураар арилгасан байдал, сануулах шийтгэл хүлээсэн этгээдийн давтан зөрчил үйлдсэн байдал, шийдвэртэй холбоотой гомдол, маргаан, эрх бүхий байгууллагын ажлын ачаалал болон шийтгэлийн биелэлтэд гарсан өөрчлөлт зэрэг үзүүлэлтээр үнэлэх боломжтой.

Эдгээр үзүүлэлтийн суурь түвшин, хэмжих хугацаа, мэдээллийн эх сурвалж, хариуцах байгууллага болон үнэлгээ хийх давтамжийг зохицуулалтын хэрэгжилтийн нөхцөлтэй уялдуулан нарийвчлан тогтоох шаардлагатай.

Ийнхүү асуудлыг шийдвэрлэх зорилго нь Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг заавал нэвтрүүлэхээр урьдчилан шийдвэрлэсэн бус, зөрчлийн шинж, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд сануулах шийтгэлийг хуульчлах нь уг зорилгод хүрэх боломжит хувилбарын нэг болно.[7]

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Өмнөх шатанд хийсэн дүн шинжилгээгээр Зөрчлийн тухай хуульд торгох шийтгэл давамгайлсан зохицуулалттай, зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт нийцсэн хариуцлагын арга хэмжээг ялгамжтай хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг тодорхойлсон. Мөн зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн хэмжээ, торгох шийтгэлийн биелэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт болон төрийн хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх чиг үүргийн уялдааг харгалзан үзэх хэрэгцээ байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын 5 дахь хэсэгт заасан шаардлагын хүрээнд асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг тодорхойлж, тэдгээрийн зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг тал, зардал, үр өгөөжийн харьцааг урьдчилсан байдлаар үнэлэв.

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс 2026 онд боловсруулсан "Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж" судалгаанд Зөрчлийн тухай хуулийн 1979 зохицуулалтыг ангилан шинжлэхэд 1062 буюу 53.7 хувьд зөвхөн торгох шийтгэл, 900 буюу 45.5 хувьд торгох шийтгэлийг бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр тусгасан байна. Ийнхүү судалгаанд хамрагдсан зохицуулалтын 99.1 хувьд торгох шийтгэлийг дангаар болон бусад арга хэмжээтэй хослуулан хэрэглэхээр заасан нь торгох шийтгэл эрх зүйн зохицуулалтад зонхилох байр суурь эзэлж байгааг илэрхийлж байна.[8]

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд оногдуулсан торгох шийтгэл, түүний биелэлт болон зөрчлийн төрөл тус бүрийн бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээллийг тусгасан байна. Энэ нь шийтгэлийн хэрэглээ,

---

[7] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт, асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлох хэсэг.

[8] Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн. (2026). Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж. Мэдээлэл, лавлагаа, судалгааны код 261002/02, х. 4–5, 26–28, 28–39.

торгуулийн биелэлт болон холбогдох байгууллагын үйл ажиллагааны нөхцөл байдлыг үнэлэхэд ашиглах боломжтой анхдагч мэдээлэл юм.[9]

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 онд боловсруулсан "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" судалгаанд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хэрэг бүртгэлтийн ажиллагаа, хариуцлага хүлээлгэх хэлбэр болон холбогдох процессын зохицуулалтын хэрэгжилтийг авч үзжээ. Энэхүү судалгаа нь шийтгэлийн шинэ төрөл нэвтрүүлэхэд материаллаг эрх зүйн зохицуулалтаас гадна түүнийг хэрэгжүүлэх процессын нөхцөл, хяналтын механизмыг хамтад нь үнэлэх шаардлагатайг харгалзан үзэхэд ач холбогдолтой байна.[10]

Дээрх судалгаа, мэдээллийн үр дүнг харгалзан асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлохдоо шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу "тэг" хувилбар, олон нийтийг соён гэгээрүүлэх, захиргааны шийдвэр болон зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбаруудыг сонгон авч судлав.

3.1. Шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу "тэг" хувилбар

Энэ хувилбарын хүрээнд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн төрлийг өөрчлөхгүй, сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэхгүй бөгөөд хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалтыг хэвээр мөрдөнө.

Үг хувилбарын эерэг тал нь хууль тогтоомжид нэмэлт оруулах шийтгэлийн шинэ төрөл хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн болон зохион байгуулалтын шинэ шаардлага үүсэхгүйд оршино. Мөн зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд одоо ашиглаж буй журам, шийдвэр гаргах болон бүртгэл, хяналтын тогтолцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой.

Харин үг хувилбарыг хэрэгжүүлснээр сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хэрэглэх эрх зүйн боломж бүрдэхгүй бөгөөд нийгмийн хор уршиг багатай, бодит хохирол учруулаагүй, үр дагаврыг богино хугацаанд арилгах боломжтой зарим зөрчилд торгохоос өөр мөнгөн бус хариуцлага хүлээлгэх боломжийг нэмэгдүүлэх зорилго хангагдахгүй байна.

Түүнчлэн торгох шийтгэлийн хэрэглээ, биелэлт болон зөрчилд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай хэрэглэхтэй холбоотой өмнөх шатанд тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх шинэ механизм бий болохгүй юм.

---

[9] Цагдаагийн ерөнхий газраас Улсын Их Хурлын гишүүний ажлын албанд ирүүлсэн зөрчлийн бүртгэл, торгох шийтгэл, түүний биелэлтийн талаарх мэдээлэл. 2026. х.3–18

[10] Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2025). *Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ.* Судалгааны тайлан. х.47–68

Зардал, үр өгөөжийн хувьд шинэ зохицуулалт хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт шууд зардал үүсэхгүй боловч одоогийн зохицуулалтын хүрээнд үүсэж буй хэрэгжилтийн зардал, хүндрэл хэвээр үргэлжилж болохыг харгалзан үзэх шаардлагатай.

Иймд "тэг" хувилбар нь эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдлыг хадгалах давуу талтай боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хэрэглэх боломжийг бүрдүүлэх зорилгод хүрэхгүй байна.

3.2. Олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар

Энэ хувилбарын хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр иргэд, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг сайжруулах, хууль сахин биелүүлэхэд чиглэсэн зөвлөн туслах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг авч үзэв.

Уг хувилбарын эерэг тал нь одоо байгаа эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгт тулгуурлан хэрэгжүүлэх боломжтойд оршино. Иргэд, хуулийн этгээдийн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сахин биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түүнчлэн эрх бүхий байгууллагаас зөрчлийн төрөл, бүртгэлийн давтамж, үйлдэгдэж буй нөхцөл байдалд үндэслэн мэдээлэл, сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой бүлэг, харилцаанд чиглүүлэх боломжтой юм.

Гэвч олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ нь Зөрчлийн тухай хуульд заагаагүй шийтгэлийн шинэ төрөл бий болгохгүй бөгөөд зөрчил үйлдсэн нь тогтоогдсон этгээдэд сануулах шийтгэл оногдуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхгүй.

Зардал, үр өгөөжийн хувьд сургалт, сурталчилгаа, мэдээлэл түгээхтэй холбоотой зардал гарах боломжтой боловч одоо байгаа байгууллагын бүтэц, хүний нөөц, мэдээллийн хэрэгслийг ашиглах нөхцөлийг судалж болно. Харин зөрчлийн давтамж, давтан үйлдэл болон хууль сахин биелүүлэх байдалд үзүүлэх бодит үр нөлөөг тусгайлан үнэлэх шаардлагатай.

Иймд энэ хувилбар нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгод дэмжлэг үзүүлэх боломжтой боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хэрэглэх эрх зүйн боломжийг дангаар бүрдүүлэхгүй байна.

3.3. Захиргааны шийдвэр гаргах, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар

Энэ хувилбарын хүрээнд хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, зөрчлийн бүртгэл,

мэдээллийн чанар, албан тушаалтны сургалт, арга зүйн удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах боломжийг авч үзэв.

Түүнчлэн хуульд зөвшөөрсөн хүрээнд төрийн хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах, илэрсэн зөрчил, дутагдлыг сайн дураар арилгуулах чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг судлав.

Уг хувилбарын зөрөг тал нь хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр хууль хэрэглээний нэгдмэл байдал, зөрчлийн бүртгэл, мэдээллийн чанар, шийдвэрийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах боломжтойд оршино.

Цагдаагийн ерөнхий газрын зөрчлийн бүртгэл, торгуулийн биелэлтийн мэдээлэл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэрэгжилтийн үнэлгээ нь эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, процессын шаардлага, бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг харгалзан үзэхэд ач холбогдолтой байна

Гэвч захиргааны шийдвэр гаргах замаар Зөрчлийн тухай хуульд заагаагүй шийтгэлийн шинэ төрөл бий болгох боломжгүй. Түүнчлэн төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлдэг зөвлөн туслах, урьдчилан сануулах, албан шаардлага өгөх зэрэг арга хэмжээ нь Зөрчлийн тухай хуулиар оногдуулах сануулах шийтгэлээс эрх зүйн шинж, үндэслэл, үр дагаврын хувьд ялгаатай юм.

Зардал үр өгөөжийн хувьд зөрчлийн бүртгэл, мэдээллийн систем, сургалт, хяналтын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нэмэлт зардал үүсэж болох боловч одоо байгаа байгууллагын бүтэц, мэдээллийн системд түшиглэн хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх шаардлагатай.

Иймд захиргааны шийдвэр болон зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон оногдуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхгүй байна.

3.4. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах буюу сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбар

Энэ хувилбарын хүрээнд Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэмж, түүнийг хэрэглэх боломжтой зөрчлийн төрөл, нөхцөл, шалгуур, хязгаарлалт болон эрх зүйн үр дагаврыг хуульчлах боломжийг авч үзэв.

Сануулах шийтгэлийг бүх төрлийн зөрчилд нийтлэг хэрэглэх бус, зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан бодит болон болзошгүй хор уршиг, анх удаа болон давтан үйлдсэн байдал, зөрчлийн үр дагаврыг арилгах боломжийг харгалзан хуульд тусгайлан заасан тодорхой төрлийн зөрчилд хэрэглэх нөхцөлийг тогтоох нь зүйтэй байна

Уг хувилбарын эерэг тал нь зөрчлийн шинж, учруулсан хохирол, хор уршгт нийцсэн хариуцлагын арга хэмжээг ялгамжтай, шаталсан байдлаар хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхэд оршино. Тухайлбал, нийгмийн хор уршиг багатай, бодит хохирол учруулаагүй, эсхүл үр дагаврыг богино хугацаанд арилгах боломжтой тодорхой төрлийн зөрчилд торгох шийтгэлийн оронд мөнгөн бус хариуцлага хүлээлгэх эрх зүйн боломж бүрдэнэ.

Мөн зөрчил үйлдсэн этгээдэд тухайн үйлдлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлан ойлгуулах, зөрчлийг сайн дураар арилгах боломж олгох, дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хариуцлагын нэмэлт механизм бүрдэж болох юм.

Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн судалгаанд санууулах арга хэмжээг торгох шийтгэлийг нийтлэг байдлаар орлуулах бус, зөрчлийн шинж, бодит болон болзошгүй хор уршиг, давтан үйлдсэн байдал, зөрчлийг арилгах боломж зэрэг нөхцөлийг харгалзан ялгамжтай хэрэглэх асуудлыг авч үзсэн байна. Түүнчлэн гадаад улсын зохицуулалтын харьцуулалтаас үзэхэд санууулах, зөрчлийг арилгах боломж олгох болон торгох шийтгэлийг шаталсан байдлаар хэрэглэх зохицуулалт харилцан адилгүй хэлбэрээр хэрэгжиж байна.

Гэвч санууулах шийтгэлийг хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуурыг тодорхой хуульчлаагүй тохиолдолд ижил шинжтэй зөрчилд ялгаатай шийдвэр гаргах, эрх бүхий албан тушаалтны үзэмжээр шийтгэл оногдуулах, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах эрсдэл үүсэж болзошгүй.

Түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн эрх, нийтийн аюулгүй байдал болон бусад эрх, хууль ёсны ашиг сонирхолд бодит хохирол, өндөр эрсдэл учруулсан зөрчилд санууулах шийтгэлийг зохисгүй хэрэглэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Иймээс санууулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээг тогтоохдоо зөвхөн торгуулийн хэмжээ болон зөрчлийн бүртгэлийн давтамжаар бус, тухайн зөрчлийн шинж, хамгаалж буй эрх, хууль ёсны ашиг сонирхол, учруулсан болон учруулж болзошгүй хор уршгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Энэ хувилбарыг хэрэгжүүлэхэд Зөрчлийн тухай хуульд шийтгэлийн шинэ төрөл нэмэхээс гадна Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг нягтлан үзэх шаардлагатай. Тухайлбал, санууулах шийтгэл оногдуулах эрх бүхий субъект, шийдвэр гаргах үндэслэл, журам, шийдвэрийн хэлбэр, бүртгэл, гомдол гаргах, хянан шийдвэрлэх журам болон давтан зөрчил үйлдсэн тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаврыг тодорхойлох асуудлыг хамтад нь авч үзнэ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 онд боловсруулсан "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн заримзүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" судалгаанд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хугацаа, хэрэг бүртгэлт, хариуцлага хүлээлгэх хэлбэр болон процессын зохицуулалтын хэрэгжилтийг авч үзсэн байна. Энэхүү судалгааны үр дүнг санууулах шийтгэлийг

нэвтрүүлэхтэй холбогдон үүсэх процессын зохицуулалт, шийдвэр гаргах ажиллагаа, бүртгэл болон хяналтын механизмыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход харгалзан үзэв.

Зардал, үр өгөөжийн хувьд сануулах шийтгэл оногдуулсан шийдвэрийг бүртгэх мэдээллийн системд өөрчлөлт оруулах, эрх бүхий албан тушаалтныг сургах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавихтай холбоотой нэмэлт зардал үүсэж болох юм. Харин хуульд тогтоосон нөхцөлийг хангасан зарим зөрчилд торгох шийтгэлийн оронд сануулах шийтгэл хэрэглэх нь иргэн, хуулийн этгээдэд учрах шууд мөнгөн төлбөрийн дарамтыг бууруулах боломжтой.

Нөгөө талаас торгох шийтгэлийн хэрэглээний бүтэц өөрчлөгдвөл улсын төсөвт төвлөрөх торгуулийн орлогын хэмжээ өөрчлөгдөх боломжтой. Иймээс сануулах шийтгэл хэрэглэхээр төлөвлөж буй зөрчлийн төрөл, тэдгээрийн бүртгэлийн давтамж, оногдуулсан болон бодитоор төлөгдсөн торгуулийн хэмжээнд тулгуурлан санхүүгийн үр нөлөөг тусгайлан тооцох шаардлагатай.

Цагдаагийн өөрийн газраас ирүүлсэн зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлт, торгох шийтгэл болон түүний биелэлтийн талаарх мэдээллийг сануулах шийтгэл хэрэглэх боломжтой зөрчлийн хүрээг тодорхойлох, зохицуулалтын санхүүгийн үр нөлөөг үнэлэхэд харгалзан үзэв. Мөн сануулах шийтгэл нэвтрүүлсний дараа зөрчлийн давтамж, давтан үйлдэл, шийтгэлийн биелэлт болон эрх бүхий байгууллагын ажлын ачаалалд үзүүлэх нөлөөг холбогдох статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн тодорхойлох нь зүйтэй.

3.5. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан үнэлгээ

Зохицуулалтын хувилбаруудыг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан үзэхэд шинээр зохицуулалт хийхээс татгалзах буюу "тэг" хувилбар нь шинэ зохицуулалт хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал шаардахгүй боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хэрэглэх эрх зүйн боломж бүрдүүлэхгүй байна.

Олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх боловч зөрчилд оногдуулах шийтгэлийн шинэ төрлийг бий болгох боломжгүй байна.

Захиргааны шийдвэр гаргах, зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбар нь хууль хэрэглээний нэгдмэл байдал, зөрчлийн бүртгэл, мэдээллийн чанар, хяналтын тогтолцоог сайжруулахад чиглэх боловч Зөрчлийн тухай хуульд заагаагүй сануулах шийтгэлийг шинээр оногдуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхгүй.

Харин хууль тогтоомжийн төсөл боловсруулах буюу Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбар нь зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт

тохирсон мөнгөн бус хариуцлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлэхэд чиглэж байна.

Гэсэн хэдий ч уг хувилбарын бодит үр нөлөө нь сануулах шийтгэлийг хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуур, шийдвэрийн бүртгэл, хяналтын тогтолцоо, хэрэгжүүлэх байгууллагын бэлэн байдал болон нэмэлт зардлаас хамаарна.

Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан үнэлгээгээр сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбар нь зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх зорилгод илүү нийцэж байна. Уг хувилбарыг хэрэгжүүлэхдээ сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуур, шийдвэрийн бүртгэл хяналт болон холбогдох байгууллагын бэлэн байдлыг хангах нь зүйтэй.

3.6. Дүгнэлт

Дээрх хувилбаруудын харьцуулсан шинжилгээнээс үзэхэд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулахад тодорхой дэмжлэг үзүүлэх боломжтой боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон оногдуулах эрх зүйн үндэслэлийг шинээр бүрдүүлэхгүй байна.

Харин Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбар нь зөрчлийн шинж, нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлагын арга хэмжээг ялгамжтай хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Гэхдээ сануулах шийтгэлийг хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуурыг тодорхой тогтоохгүйгээр хэрэгжүүлсэн тохиолдолд хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах, зөрчлийн улмаас хохирсон этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хангалттай хамгаалагдахгүй байх болон шийтгэлийн урьдчилан сэргийлэх үр нөлөө сулрах эрсдэл үүсэж болзошгүй.

Иймд зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан үнэлгээнд үндэслэн Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбарыг сонгох нь зүйтэй гэж дүгнэв. Уг хувилбарыг хэрэгжүүлэхдээ сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуур, холбогдох хууль тогтоомжийн уялдаа, шийдвэр гаргах, бүртгэх болон хяналт тавих ажиллагааг хамтад нь зохицуулах шаардлагатай.

Хүснэгт 1

№	Хувилбар	Зорилгод	Зөрөг тал	Сөрөг тал, эрсдэл

		хүрэх байдал		
1	"Тэг" хувилбар	Сануулах шийтгэлийн эрх зүйн боломж бүрдэхгүй.	Шинэ зохицуулалтын зардал үүсэхгүй.	Өмнө тодорхойлсон асуудал хэвээр үлдэнэ.
2	Соён гэгээрүүлэх	Урьдчилан сэргийлэх зорилгод хэсэгчлэн нөлөөлнө.	Иргэдийн эрх зүйн мэдлэг, хууль сахилтыг дэмжинэ.	Бие даасан шийтгэлийн төрөл бий болохгүй.
3	Захиргааны болон зохион байгуулалтын арга хэмжээ	Хэрэгжилтийг сайжруулах боломжтой.	Бүртгэл, хяналт, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг дэмжинэ.	Хуулиар тогтоогоогүй шийтгэлийг бий болгохгүй.
4	Сануулах шийтгэлийг хуульчлах	Шинэ шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.	Хариуцлагыг ялгамжтай хэрэглэх боломж нэмэгдэнэ.	Хэрэглэх шалгуур, мэдээллийн систем, сургалт, хяналтын зардал болон эрх зүйн эрсдэл үүсэж болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг, Арван зургаадугаар зүйлд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх төрийн үүргийг тус тус баталгаажуулсан. Мөн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг болохыг тогтоосон байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчлийн шинжийг хуулиар тодорхойлох, 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөрчилд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх зарчмыг тусгасан байна. Иймд сануулах шийтгэлийг хуульд тодорхойлсон нөхцөл, шалгуурын хүрээнд хэрэглэх нь дээрх зарчмыг бодитой хэрэгжүүлэх, зөрчилд тохирсон хариуцлагын арга хэмжээг сонгох эрх зүйн боломжийг нэмэгдүүлнэ.

Тухайлбал, хуульд тусгайлан заасан, анх удаа үйлдсэн, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд бодит хохирол, хор уршиг учруулаагүй буюу учирсан хор уршгийг арилгах боломжтой зөрчлийн хувьд тухайн этгээдэд зөрчлийн хууль зүйн үр дагаврыг тайлбарлан ойлгуулж, зөрчлөө арилгах, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломж олгох нь хариуцлагын зорилгыг хэрэгжүүлэх өөр нэг хэлбэр болно.

Ингэснээр сануулах шийтгэл нь зөрчил үйлдсэн этгээдийг хариуцлагаас үндэслэлгүй чөлөөлөх бус, харин тухайн зөрчлийн шинж, үр дагаварт тохирсон хариуцлага хүлээлгэх боломжийг нэмэгдүүлж, хүний эрхийг хүндэтгэхэд эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэл нэвтрүүлэх нь иргэн, хуулийн этгээдэд ногдуулах мөнгөн торгуулийн ачаалал, улсын төсвийн торгуулийн орлого болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд эдийн засгийн нөлөө үзүүлэх боломжтой. Иймд зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ одоогийн торгох шийтгэлийн бүтэц, ногдуулсан торгуулийн хэмжээ болон сануулах шийтгэл хэрэглэх боломжтой зөрчлийн хүрээг харгалзан үзэх шаардлагатай.

УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2026 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн *"Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж"* судалгаанд Зөрчлийн тухай хуульд тусгагдсан 1,979 шийтгэлийн зохицуулалтыг шинжилжээ. Үүнээс 1,062 буюу 53.7 хувь нь зөвхөн торгох шийтгэл ногдуулахаар, 900 буюу 45.5 хувь нь торгох шийтгэлийг бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр зохицуулагдсан байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамруулсан зохицуулалтын 99.1 хувьд торгох шийтгэл дангаар буюу бусад арга хэмжээтэй хослон тусгагджээ. Энэ нь Зөрчлийн тухай хуульд мөнгөн торгууль ногдуулсан хэрэглэгдэг хариуцлагын хэлбэр болохыг харуулж байна.

Тус судалгаанд Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн статистик мэдээлэлд үндэслэн 2023–2025 онд ногдуулсан торгуулийн дүнг нэгтгэжээ. 2025 онд хүн болон хуулийн этгээдэд ногдуулсан торгуулийн нийт дүн 194.58 тэрбум төгрөгт хүрч, 2024 оныхоос ойролцоогоор 84.8 хувиар өссөн байна. Тухайлбал, хуулийн этгээдэд ногдуулсан торгуулийн дүн 2024 онд 19.29 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 81.02 тэрбум төгрөг болж нэмэгджээ. Энэ нь торгох шийтгэл иргэнээс

гадна аж ахуйн нэгжийн санхүүгийн байдалд нөлөөлөх хэмжээний мөнгөн үүрэг үүсгэж байгааг харуулна.

Гэхдээ дээрх дүн нь ногдуулсан торгуулийн хэмжээ бөгөөд бодитоор төвлөрүүлсэн орлого, эсхүл сануулах шийтгэлээр солих боломжтой торгуулийн хэмжээг дангаар илэрхийлэхгүй. Иймээс нийт торгуулийн дүнг сануулах шийтгэл нэвтрүүлснээр буурах төсвийн орлоготой шууд адилтгах боломжгүй.

Хуульд тусгайлан заасан, сануулах шийтгэл хэрэглэх шалгуурыг хангасан зөрчилд мөнгөн торгуулийн оронд сануулах шийтгэл хэрэглэх нь тухайн иргэн, хуулийн этгээдийн шууд санхүүгийн ачааллыг бууруулах боломжтой. Ялангуяа жижиг, дунд аж ахуйн нэгжийн хувьд торгууль төлөхөд зарцуулсан хөрөнгө нь үйл ажиллагааны зардал, бараа материалын худалдан авалт болон бусад хэрэгцээнд зарцуулах боломжтой мөнгөн хөрөнгийг багасгаж болно. Иймд зөрчлийн шинж, учруулсан хохирол, хор уршгит тохируулан сануулах шийтгэл хэрэглэх нь зөрчлийг арилгахын зэрэгцээ эдийн засгийн үндэслэлгүй дарамт үүсгэхээс сэргийлэх боломжтой.

Сануулах шийтгэл хэрэглэснээр хамрагдах зөрчлүүдэд ногдуулах торгуулийн орлого буурах боломжтой. Харин торгуулийг төлүүлэх, төлөгдөөгүй торгуулийг албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой зарим ажиллагаа багасах боломжтой боловч сануулах шийтгэлийг бүртгэх, шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа мөн шаардагдана.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Улсын ерөнхий прокурорын газрын мэдээллээр 2025 онд улсын хэмжээнд нийт 4,831,351 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос 45.3 хувиар өссөн байна. Үүний 93.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил эзэлж, олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах 149,628 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оноос 31.5 хувиар өсжээ

Эдгээр тоон мэдээлэл нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль сахин биелүүлэх хандлагыг төлөвшүүлэх, хариуцлагын тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах шаардлагыг харуулж байна. Гэхдээ бүртгэгдсэн зөрчил бүрд сануулах шийтгэл хэрэглэх боломжгүй бөгөөд тухайн зөрчлийн шинж, учруулсан хохирол, хор уршиг, давтан үйлдсэн эсэх болон зөрчлийг арилгах боломжийг харгалзан үзэх шаардлагатай.

Сануулах шийтгэлийг хуульд заасан шалгуурыг хангасан, нийгэмд учруулах хор уршиг багатай зарим зөрчилд хэрэглэх нь иргэн, хуулийн этгээдэд зөрчлийн шалтгаан, үр дагаврыг ойлгуулж, зөрчлийг арилгах, дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлнэ. Ингэснээр хариуцлагыг зөвхөн шийтгэл ногдуулахад чиглүүлэх бус, хууль сахин биелүүлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглүүлэх ач холбогдолтой

Мөн зөрчил бүрд торгох шийтгэл ногдуулахын оронд зөрчлийн нөхцөл байдалд тохирсон хариуцлага хэрэглэх нь иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл, хариуцлагын тогтолцоог шударга, зохистой гэж хүлээн авах хандлагад эерэгээр нөлөөлөх боломжтой.

Иймд сануулах шийтгэлийг хэрэглэх зөрчлийн төрөл, нөхцөл, шалгуурыг хуульд тодорхой зааж, шийдвэр гаргах ажиллагаанд нэгдмэл байдлыг хангах нь чухал. Түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдалд бодит эрсдэл учруулсан, эсхүл давтан үйлдэгдсэн зөрчилд сануулах шийтгэлийг зохисгүй хэрэглэхээс сэргийлэх шаардлагатай.

4.4. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцнэ.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл, учирсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон зөрчлийг сайн дураар арилгуулах боломжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан үнэлэв.

Үнэлгээнд хуулийн төслийн үзэл баримтлал, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн судалгаа, байгууллага, аймгуудаас ирүүлсэн хэрэгжилтийн мэдээллийг ашиглаж, хувилбаруудын зорилгод хүрэх байдал, хэрэгжих боломж, зардал, үр өгөөж болон болзошгүй эрсдэлийг авч үзлээ.

5.1. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт

Гуравдугаар бүлэгт асуудлыг шийдвэрлэх боломжит дөрвөн хувилбарыг авч үзсэн. Эдгээрээс хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр хэрэгжүүлэх эхний гурван хувилбарыг нэгтгэн, сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх дөрөвдүгээр хувилбартай харьцуулан үнэлэв. Ийнхүү зохицуулалтын хувилбаруудыг нэгтгэхдээ зорилгод хүрэх байдал, хүний эрх, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөж болон хэрэгжих боломжийг харгалзан үзсэн болно.

Хүснэгт 2

№	Шалгуур үзүүлэлт	Хувилбар 1	Хувилбар 2

1	Зохицуулалтын хувилбарууд	Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн төрлийг өөрчлөхгүйгээр хууль хэрэглээ, сургалт, зөвлөн туслах ажилллагаа, бүртгэл, хяналт болон шийтгэлийн биелэлтийг сайжруулах замаар асуудлыг шийдвэрлэх.	Зөрчлийн тухай хуульд тусгайлан заасан зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх зохицуулалт нэвтрүүлж, хэрэглэх нөхцөл, шийдвэр, бүртгэл, давтан үйлдлийн үр дагаврыг тодорхойлон, одоогийн ажиллагааг сайжруулах арга хэмжээтэй хослуулан асуудлыг шийдвэрлэх.
2	Зорилгод хүрэх байдал	Хууль хэрэглээний алдааг багасгах, ажиллагааны хүндрэлийг бууруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Гэвч тодорхой зөрчилд мөнгөн торгуульгүй албан ёсны хариуцлага хэрэглэх сонголт бий болохгүй тул үзэл баримтлалын зорилгыг бүрэн хангахгүй.	Үзэл баримтлалд заасан нөхцөл хангасан зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх боломж бүрдүүлнэ. Зөрчлийн нөхцөлд тохирсон хариуцлага сонгох, анх удаагийн болон давтан үйлдлийг ялгах, зөрчлийг сайн дураар арилгуулах зорилгод хүрэх боломжтой.
3	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Шийдвэрийн үндэслэл, гомдлын хяналт, сургалт, мэдээлэл болон хяналтын чанарыг сайжруулснаар эрхийн хамгаалалт, хууль сахилтыг дэмжинэ. Торгуулийн төлбөрийн үүрэг хэвээр боловч ажиллагааг хялбарчилснаар захиргааны зардлыг бууруулж болно. Байгаль орчны хамгаалалтын одоогийн зохицуулалт үргэлжилнэ.	Сануулах нөхцөл хангасан иргэн, хуулийн этгээдийн торгуулийн төлбөрийн ачаалал буурч, зөрчлийг засаж залруулах боломж нэмэгдэнэ. Гэхдээ шалгуур тодорхой бус бол ялгаатай хэрэглээ үүсэх, өндөр эрсдэлтэй зөрчилд хамгаалалт сулрах эрсдэлтэй. Байгаль орчинд үзүүлэх нөлөөг сонгосон зөрчил бүрийн бодит болон болзошгүй хор уршгаар үнэлнэ.

4	Зардал, үр өгөөжийн харьцаа	Сургалт, бүртгэл, хяналт, байгууллагын чадавхыг сайжруулах зардал гарна. Үр өгөөж нь одоогийн ажиллагааны чанар, шуурхай байдал сайжрахад илэрнэ. Шийтгэлийн сонголтын хязгаарлалт хэвээр үлдэнэ.	Системийн өөрчлөлт, маягт, сургалт, нөхцөл шалгах болон бүртгэх ажиллагааны зардал гарна. Үр өгөөж нь сонгосон тохиолдолд торгуулийн ачаалал буурах, тохирсон хариуцлага хэрэглэх боломж нэмэгдэхэд илэрнэ. Зардал, үр өгөөжийн мөнгөн харьцааг тогтоох мэдээлэл одоогоор хангалтгүй.
5	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Арга хэмжээг байгууллагын хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. Дотоод журам, зөвлөмжөөр хуульд тогтоосон шийтгэлийг өөрчлөх, орлуулах боломжгүй.	Шийтгэлийн төрөл, ангилал, түсгай английн санкц болон процессын зохицуулалтыг хамтад нь нийцүүлнэ. Хэрэглэх нөхцөл, эрх хэмжээ, гомдлын баталгааг тодорхой болгож, Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхлыг хангана.
6	Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээд	Зөрчилд холбогдогч иргэн, хуулийн этгээд; хохирогч болон эрх нь зөрчигдөж болзошгүй этгээд; хууль хэрэгжүүлэгч байгууллага, эрх бүхий албан тушаалтан; прокурор, шүүх; шийдвэр гүйцэтгэх болон төсвийн байгууллага.	Зөрчилд холбогдогч иргэн, хуулийн этгээд; хохирогч болон эрх нь зөрчигдөж болзошгүй этгээд; хууль хэрэгжүүлэгч байгууллага, эрх бүхий албан тушаалтан; прокурор, шүүх; бүртгэл, мэдээллийн систем болон төсвийн асуудал хариуцсан байгууллага.

5.2. Гарч болох эерэг үр дүн

Нэгдүгээр хувилбар нь одоо байгаа байгууллагын тогтолцоонд түшиглэн хууль хэрэглээ, хяналт, сургалт, зөвлөн туслах болон шийтгэлийн биелэлтийг сайжруулах боломжтой. Архангай, Нийслэлийн ЗДТГ, ХХААХҮЯ-ны мэдээлэлд дурдсан эрх, харьяаллын хүндрэл, Баян-Өлгийн мэдээлэлд хөндсөн давхар бүртгэл, Боловсролын яамны дурдсан шийдвэрийн биелэлтийн асуудлыг

шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч болно. Ингэснээр ажиллагааны чанар, шуурхай байдал, шийдвэрийн үндэслэл болон эрхийн хамгаалалтыг сайжруулах боломж бүрдэнэ.

Хоёрдугаар хувилбар нь эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хуульд сонгосон зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх эрх зүйн боломж бий болгоно. Архангай, Говьсүмбэр, Дорнодын мэдээлэлд дурдсан торгуулийн хэмжээ, бодит нөхцөлийн тохирцын асуудал, Боловсролын яамны хөндсөн шаталсан хариуцлагын хэрэгцээ, Тээврийн цагдаагийн тодорхой зөрчилд сануулах саналтай уялдана.

Үзэл баримтлалд заасан нөхцөл хангасан тохиолдолд мөнгөн торгуульгүй хариуцлага хэрэглэх нь иргэн, хуулийн этгээдийн төлбөрийн ачааллыг бууруулж, зөрчлийн хууль зүйн үр дагаврыг ойлгуулах, сайн дураар засаж залруулах боломжийг нэмэгдүүлнэ. Сануулах шийдвэрийг бүртгэснээр анх удаагийн болон давтан үйлдлийг ялган үнэлэх нөхцөл бүрдэнэ.

5.3. Гарч болох сөрөг үр дагавар

Нэгдүгээр хувилбар нь шийтгэлийн төрлийг өөрчлөхгүй тул хуульд заасан торгуулийг сануулах шийтгэлээр орлуулах боломж бий болгохгүй. Сургалт, мэдээлэл, зөвлөн туслах ажиллагааг сайжруулсан ч зөрчил тогтоосны дараах хариуцлагын сонголт хэвээр үлдэнэ. Байгууллагын хүний нөөц, санхүүжилт, эрх, харьяаллын асуудал шийдвэрлэгдээгүй тохиолдолд хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний үр дүн хязгаарлагдаж болно.

Хоёрдугаар хувилбар нь сануулах нөхцөлийг шалгах, өмнөх шийдвэрийг нягтлах, үндэслэл бичих, тайлбарлах, бүртгэх ажиллагаа шаардана. Шалгуур тодорхой бус, бүртгэл дутуу байвал ижил нөхцөлд үндэслэлгүйгээр ялгаатай шийдвэр гаргах, давтан үйлдлийг анх удаагийн гэж буруу тооцох эрсдэлтэй. Мөн систем шинэчлэх, сургалт зохион байгуулах болон ажиллагааны нэмэлт зардал үүснэ.

Автотээвэр хөдөлмөр, хүүхэд хамгаалал, харилцаа холбооны байгууллагуудын дурдсан эрсдэлийг үл харгалзан сануулах хүрээг өргөжүүлбэл хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдал болон бусад хамгаалагдсан ашиг сонирхлын хамгаалалт сулрах боломжтой. Иймээс анх удаа үйлдсэн, бодит хохирол гараагүй байхыг дангаар нь сануулах хангалттай үндэслэл гэж үзэхгүй.

5.4. Харьцуулсан дүгнэлт

Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулахад хуульд тусгайлан заасан зөрчилд сануулах шийтгэл нэвтрүүлэх хоёрдугаар хувилбар нь үзэл баримтлалд тодорхойлсон зорилгод хүрэх боломжтой гэж үзэв. Иймд уг хувилбарыг сонгож, хууль хэрэглээ сургалт, зөвлөн туслах ажиллагаа, бүртгэл, хяналт болон шийтгэлийн бие даалтыг сайжруулах арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Сануулах шийтгэлийг торгуулийг автоматаар орлох арга хэмжээ бус, зөвхөн хуульд тогтоосон зөрчил, нөхцөлөөр хэрэглэнэ. Хэрэглэх хүрээг тогтоохдоо үзэл баримтлалд тусгасан анх удаагийн үйлдэл, хохирол, хор уршиг, зөрчлийг арилгах боломж болон нийгмийн хор аюулын шинж, хэмжээг харгалзаж, шийдвэрийн үндэслэл, бүртгэл, гомдлын хяналт, давтан үйлдлийн үр дагаврыг тодорхой зохицуулна.

Байгууллага, аймгуудаас ирүүлсэн мэдээлэлд дурдсан эрх, харьяалал, хүний нөөц, давхар бүртгэл болон шийдвэрийн биелэлтийн хүндрэл нь сануулах шийтгэл нэвтрүүлснээр дангаараа шийдвэрлэгдэхгүй тул шаардлагатай эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээг хамтад нь авна.

Сануулах шийтгэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой системийн өөрчлөлт, сургалт, бүртгэл, хяналтын зардлыг холбогдох байгууллагуудын батлагдсан төсөв, одоо байгаа нөөцөд тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг харгалзан үзсэн. Төсвийн торгуулийн орлогод үзүүлэх боломжит нөлөөг сануулах шийтгэлд хамруулах зөрчлийн хүрээнээс хамааруулан үнэлнэ.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

6.1. Судалгааны зорилго, хамрах хүрээ

Зөрчлийн тухай хуульд сануулах арга хэмжээ хэрэглэх зохицуулалт нэвтрүүлэх асуудлыг судлахдаа гадаад улсын хууль тогтоомжид зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг харгах тогтолцоо торгох шийтгэлийн оронд сануулах арга хэмжээ хэрэглэх боломжийг ямар нөхцөлөөр хязгаарладаг, зөрчлийг арилгах хугацаа олгох болон давтан зөрчилд хариуцлага хүлээлгэх асуудлыг хэрхэн зохицуулдгийг харьцуулан авч үзлээ.

Энэ хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Оросын Холбооны Улс, Португал Улс, Их Британи болон Франц Улсын холбогдох хууль тогтоомжийг судлав. Эдгээр улсын зохицуулалтыг сонгохдоо сануулах арга хэмжээг захиргааны зөрчлийн бие даасан шийтгэл болгон хэрэглэх, ялимгүй зөрчилд торгуулийн оронд сонгон хэрэглэх, эсхүл зөрчлийг арилгах боломж олгосны дараа торгох арга хэмжээ авах гэсэн ялгаатай хэлбэрүүдийг хамруулахыг зорив.

Харьцуулсан судалгаанд дараах шалгуурыг ашиглав:

- Сануулах арга хэмжээ нь бие даасан шийтгэл мөн эсэх;
- Сануулах арга хэмжээг хэрэглэх зөрчлийн шинж, хор уршиг болон давтамжид тавих шаардлага,
- Зөрчлийг арилгах хугацаа олгох, мэдэгдэл хүргүүлэх боломж;
- Сануулах арга хэмжээ болон торгох шийтгэлийн уялдаа;
- Сануулга эгсний дараа зөрчлийг арилгаагүй, эсхүл дахин үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага;

- Сануулах арга хэмжээ хэрэглэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон шийдвэр гаргах ажиллагааны зохицуулалт

Энэ судалгаанд "сануулах арга хэмжээ" гэсэн ойлголтыг өргөн хүрээнд авч үзсэн боловч сануулах шийтгэл, зөрчлийг арилгах тухай албан ёсны шаардлага, торгуулийн мэдэгдэл нь эрх зүйн үр дагаврын хувьд ялгаатай болохыг анхаарав. Тухайлбал, сануулах шийтгэл нь зөрчилд хариуцлага хүлээлгэх хэлбэр байж болох бол зөрчлийг арилгах мэдэгдэл нь торгууль ногдуулахын өмнө хуульд заасан үүргээ биелүүлэх боломж олгох ажиллагаа байж болно.

6.2. Гадаад улсын эрх зүйн зохицуулалт

6.2.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Захиргааны зөрчлийн тухай хууль (Gesetz über Ordnungswidrigkeiten — OWiG)-ийн 56 дугаар зүйлд захиргааны зөрчил ялимгүй шинжтэй тохиолдолд эрх бүхий захиргааны байгууллага тухайн этгээдэд сануулах арга хэмжээ хэрэглэх боломжийг тусгасан байна. Уг зохицуулалтаар эрх бүхий байгууллага 5–55 еврогийн сануулах төлбөр ногдуулах, эсхүл төлбөргүйгээр сануулах боломжтой

Хуулийн 56 дугаар зүйлд заасан сануулга нь зөвхөн зөрчил гаргагчид анхааруулга өгөх тэдий бус, хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд тухайн үйлдэлтэй холбоотой хариуцлагын ажиллагааг эцэслэх эрх зүйн үр дагавартай. Төлбөртэй сануулгын хувьд тухайн этгээд сануулгыг хүлээн зөвшөөрч, тогтоосон хугацаанд төлбөрөө төлсөн байх шаардлагатай. Хуульд сануулах төлбөр төлөх хугацааг өөрчлөх нэг долоо хоног байхаар тогтоосон байна

Энэхүү зохицуулалтын онцлог нь захиргааны зөрчил бүрд ижил хэмжээний хариуцлага ногдуулахын оронд зөрчлийн ялимгүй шинжийг харгалзан сануулах арга хэмжээ сонгох боломж олгож байгаа явдал юм. Гэхдээ хуулийн 56 дугаар зүйлд заасан сануулгыг бүх зөрчилд заавал эхэлж хэрэглэх шаардлагагүй бөгөөд тухайн зөрчлийн нөхцөл байдлаас хамаарч шийдвэрлэнэ.

6.2.2. Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №195-ФЗ Захиргааны зөрчлийн тухай кодекс-ын 3.4 дүгээр зүйлд сануулах арга хэмжээг захиргааны шийтгэлийн төрөл гэж тодорхойлсон байна. Сануулах арга хэмжээ нь иргэн, хуулийн эт эдийн үйлдэлд албан ёсоор буруушаасан үнэлэлт өгөх бөгөөд бичгээр үйлдэх ёстой

Тус зүйлийн 2 дахь хэсэгт сануулах шийтгэлийг анх удаа үйлдсэн, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, төрийн аюулгүй байдал болон хуульд заасан бусад хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулаагүй, хохирол учрах аюул бий болгосгүй эд хөрөнгийн хохирол үүсгээгүй захиргааны зөрчилд тогтоох нөхцөлийг

тусгасан байна. Иймхүү сануулах шийтгэлийг хэрэглэхдээ зөрчлийн анхны эсэхээс гадна түүний бодит үр дагавар болон учруулж болох эрсдэлийг харгалздаг.

ОХУ-ын зохицуулалтын онцлог нь сануулах шийтгэлийг зөвхөн тодорхой төрлийн зөрчлийн тусгай санкцид заасан эсэхээр хязгаарлахгүй, хуульд заасан нөхцөлийг хангасан тохиолдолд ерөнхий журмаар хэрэглэх боломжийг бүрдүүлсэн явдал юм. Гэхдээ энэ нь аливаа зөрчлийг сануулах арга хэмжээгээр орлуулах боломжтой гэсэн үг биш бөгөөд тухайн зөрчлийн тусгай зохицуулалт, хор уршиг, эрсдэл болон бусад хуульд заасан нөхцөлийг хамтад нь харгалзах шаардлагатай.

6.2.3. Португал Улс

Португал Улсын байгаль орчны захиргааны зөрчлийн тухай ерөнхий зохицуулалт болох Lei n.º 50/2006 — Lei-Quadro das Contraordenaçöes Ambientais-ийн 47А дугаар зүйлд доорхой нөхцөлд зөрчил гаргагчид сануулах мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилгах боломж олгохоор зохицуулсан байна.

Уг зохицуулалтаар байгаль орчны хөнгөн зөрчил үйлдсэн, өмнөх таван жилийн хугацаанд байгаль орчны хүнд болон маш хүнд зөрчилд шийтгүүлээгүй, мөн тухайн төрлийн зөрчилд өмнө нь сануулга авснаас хойш гурван жилээс дээш хугацаа өнгөрсөн зэрэг нөхцөлийг хамтад нь хангах шаардлагатай. Эрх бүхий байгууллага зөрчил гаргагчид тодорхой хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлсэн зөрчлийн нөхцөл байдлыг арилгасан гэдгээ нотлох шаардлага тавьж болно. Шаардлагыг биелүүлсэн бол зөрчлийн ажиллагаа хаах, биелүүлээгүй бол харилцагын ажиллагааг үргэлжлүүлэх зохицуулалттай.

Энэхүү зохицуулалт нь сануулга хүргүүлэхийг зөрчлийг ямар ч үр дагаваргүйгээр өчгөрөөх арга хэмжээ бус, хууль зөрчсөн нөхцөл байдлыг арилгуулахад чиглэсэн механизм болгон ашиглаж байгаагаараа онцлог юм. Мөн сануулга хэрэглэхэд өмнөх зөрчил, өмнө нь сануулга авсан эсэх болон зөрчлийн ангиллыг харгалзан үздэг.

6.2.4. Их Британи

Их Британийн эрх зүйн тогтолцоонд зарим төрлийн зөрчлийн хувьд шууд торгууль ногдуулахын оронд эхлээд зөрчлийг арилгах тухай бичгээр сануулах мэдэгдэл хүргүүлж, тогтоосон шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах зохицуулалт байдаг.

Тухайлбал, Environmental Protection Act 1990-ийн 46А дугаар зүйлд Англид айл өрхийн хог хаягдлын сав ашиглах, байрлуулах болон хог цуглуулахтай холбоотой эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлагыг биелүүлээгүй, улмаар орчны тав тухад сөргөөр нөлөөлсөн буюу нөлөөлөх магадлалтай тохиолдолд бичгээр сануулах мэдэгдэл хүргүүлэх боломжийг тусгасан. Уг мэдэгдэлд зөрчсөн шаардлага, зөрчлийн шинж чанарыг тусгасан буюу учруулж болзошгүй сөрөг нөлөө, зөрчил үргэлжилж байгаа бол арилгах хугацаа болон шаардлагыг биелүүлээгүй

тохиолдолд үүсэх ур дагаврыг тодорхой тусгана. Хэрэв тухайн этгээд тогтоосон хугацаанд шаардлагыг биелүүлээгүй, эсхүл нэг жилийн хугацаанд ижил буюу төстэй зөрчлийг дахин гаргасан бол хуульд заасан журмын дагуу мөнгөн торгууль ногдуулах боломжтой.

Мөн Noise Act 1996-ийн 3 4, 8 дугаар зүйлд шөнийн цагаар зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ гаргасан тохиолдолд эхлээд сануулах мэдэгдэл хүргүүлж, мэдэгдэлд заасан хугацаанд зөрчил үргэлжилсэн бол хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Энэ тохиолдолд эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээний торгууль төлөх мэдэгдэл хүргүүлж болох бөгөөд уг төлбөрийг төлснөөр тухайн зөрчлийн улмаас шүүхээр ял шийтгүүлэх хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой Гэхдээ торгуулийн мэдэгдэл нь сануулах мэдэгдэлтэй адил бус, зөрчилд хариуцлага хүлээлгэх өөр механизм юм.

Их Британийн жишээнээс харахад зөрчлийн шинж, учруулж болзошгүй хор уршгийг харгалзан үзэж, зөрчлийг арилгах боломжтой тохиолдолд эхлээд бичгээр сануулах, шаардлагыг биелүүлэх хугацаа олгох харин шаардлагыг биелүүлээгүй буюу зөрчлийг дахин гаргасан тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах шаталсан зохицуулалтыг хэрэглэж байна

6.2.5. Франц Улс

Франц Улсын эрх зүйн тогтолцоонд захиргааны сануулга (avertissement) өгөх болон мөнгөн торгууль ногдуулах арга хэмжээг тухайн зөрчлийн нөхцөл байдлаас хамааруулан сонгох зохицуулалт байдаг.

Тухайлбал Францын Code du travail буюу Хөдөлмөрийн тухай хуулийн L8115-1 дүгээр зүйлд хөдөлмөрийн хууль тогтоомжийн тодорхой шаардлагыг зөрчсөн тохиолдолд эрх бүхий захиргааны байгууллага ажил олгогчид сануулга өгөх, эсхүл захиргааны торгууль ногдуулах боломжийг тусгасан L8115-4 дүгээр зүйлд эдгээр арга хэмжээг сонгох болон торгуулийн хэмжээг тогтоохдоо зөрчлийн нөхцөл байдал, хүндийн зэрэг зөрчил гаргагчийн зан үйл, түүний дотоо шударга сэтгэл, санхүүгийн боломж, төлбөрийн чадварын хэмжээ зэргийг харгалзахаар заасан байна Мөн L8115-5 дугаар зүйлд шийдвэр гаргахаас өмнө холбогдох этгээдэд ногдуулахаар төлөвлөж буй арга хэмжээ болон зөрчлийн талаар бичгээр мэдэгдэх тайлбар, саналаа гаргах боломж олгохоор зохицуулжээ

Түүнчлэн L8115-3 дугаар зүйлд өмнө нь ижил төрлийн зөрчилд сануулга авснаас хойш нэг жилийн дотор дахин зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн дээд хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэхээр заасан байна.

Энэ зохицуулалт нь сануулах арга хэмжээ хэрэглэх эсэхийг зөвхөн зөрчил анх удаа үйлдэгдсэн эсэхээр хязгаарлахгүй, зөрчлийн шинж, хүндийн зэрэг болон тухайн этгээдийн нөхцөл байдлыг хамтад нь үнэлэх боломж олгож байгаагаараа онцлог юм. Гэхдээ уг зохицуулалт нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн тодорхой зөрчилд хамаарах тул Францын бүх төрлийн захиргааны зөрчилд адил үйлчилдэг нийтлэг журам тогтоож болохгүй

6.3. Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд тусгах боломж

Гадаад улсын зохицуулалтаас үзэхэд сануулах арга хэмжээг Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд тусгахдаа зөвхөн шийтгэлийн нэг төрөл нэмэх эсэх асуудлаар хязгаарлахгүй, харин түүнийг ямар үндэслэлээр хэрэглэх, ямар үр дагавартай байх, зөрчлийг арилгах ажиллагаатай хэрхэн уялдуулахыг цогцоор нь авч үзэх шаардлагатай.

6 3.1. Сануулах арга хэмжээ хэрэглэх үндэслэлийг тодорхойлох

ОХУ болон Германы эрх зүйн зохицуулалтын жишээнээс үзэхэд сануулах арга хэмжээ хэрэглэхдээ зөрчлийн шинж, хүндийн зэрэг, анх удаа үйлдсэн эсэх болон хор уршгийг харгалзаж байна.

Иймд Монгол Улсад сануулах арга хэмжээ хэрэглэх үндэслэл, нөхцөлийг тодорхойлохдоо дараах шалгуурыг хуульд тусгах боломжтой Үүнд:

- Зөрчил анх удаа үйлдэгдсэн эсэх,
- Зөрчлийн улмаас бодит хохирол учирсан эсэх;
- Хүний амь нас эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдал болон бусад хамгаалагдсан ашиг сонирхолд эрсдэл бий болсон эсэх;
- Зөрчлийг арилгах боломж, зөрчил гаргагчийн авсан арга хэмжээ;
- Өмнө нь санчлаар арга хэмжээ авсан эсэх, ижил төрлийн зөрчил давтан үйлдэгдсэн эсэх,
- Тухайн зөрчлийн тусгай зохицуулалт сануулах арга хэмжээ хэрэглэхийг зөвшөөрсөн эсэх

Эдгээр нөхцөлийг хуульд тодорхой зааснаар ижил төстэй нөхцөлтэй зөрчилд адил хандах шийдвэрийг үндэслэлтэй гаргах боломж бүрдэнэ.

6.3.2. Сануулах шийтгэл болон зөрчлийг арилгах мэдэгдлийг ялгаж зохицуулах

Германы Зөрчлийн тухай хууль (OWiG)-ийн 56 дугаар зүйлд зөрчил ялимгүй шинжтэй тохиолдолд эрх бүхий байгууллагаас төлбөртэй болон төлбөргүй сануулга өгөх журмыг зохицуулсан бол ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлд сануулгыг захиргааны шийтгэлийн бие даасан төрөл болгон хуульчилсан байна. Харин Португал болон Их Британийн зарим зохицуулалтад зөрчлийг арилгах чиглэлтэй мэдэгдэл хүргүүлэх механизмыг ашигладаг

Иймд Монгол Улсад дараах хоёр механизмыг ялгаж үзэх боломжтой.

1. Сануулах шийтгэл: Хуульд заасан нөхцөлийг хангасан зөрчилд торгуулийн оронд хэрэглэх бие даасан хариуцлагын төрөл.
2. Зөрчлийг арилгах тухай мэдэгдэл: Зөрчлийг арилгах боломжтой нөхцөлд эрх бүхий байгууллагаас тодорхой хугацаатай шаардлага хүргүүлж,

биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлагын арга хэмжээнд шилжих ажиллагаа

Энэ хоер хэлбэрийг ялган зохицуулах нь сануулгын эрх зүйн үр дагавар, зөрчлийг арилгах үүрэг, хариуцлагын дараагийн шат болон эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг тодорхой болгоход ач холбогдолтой.

6.3.3. Давтан зөрчил болон бодит хор уршигтай тохиолдолд хэрэглэх хязгаарлалт тогтоох

ОХУ-ын зохицуулалт анх удаа үйлдсэн, хуульд заасан хор уршиг, эрсдэлгүй зөрчилд сануулах шийтгэл тогтоох нөхцөлийг тодорхойлдог Португалын байгаль орчны зөрчлийн зохицуулалт өмнөх зөрчлийн түүх болон өмнө сануулга авсан эсэхийг харгалздаг.

Үүнтэй уялдуулан Монгол Улсад ижил төрлийн зөрчлийг давтан үйлдсэн, зөрчлийг арилгах тухай шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний эрх, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдал болон бусад хамгаалагдсан ашиг сонирхолд бодит хохирол аюул учруулсан тохиолдолд сануулах арга хэмжээ хэрэглэхгүй байх нөхцөлийг тусгах боломжтой.

Өөхдөө давтан зөрчил, хор уршиг болон бусад нөхцөлийг бүх төрлийн зөрчилд ижил байдлаар хэрэглэх эсэхийг тухайн зөрчлийн агуулга, хамгаалж буй эрх, ашиг сонирхолтой уялдуулан шийдвэрлэх шаардлагатай.

6.3.4. Шийдвэр гаргах ажиллагаа, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрхийг тодорхой болгох

Францын Кодексийн тухай хуулийн L8115-4–L8115-5 дугаар зүйлд сануулга болгон торгуулийн аль нэгийг сонгохдоо зөрчлийн нөхцөл байдлыг харгалзах шийдвэр гаргахаас өмнө холбогдох этгээдэд мэдэгдэж, тайлбар гаргах боломж олгох ажиллагааг тусгасан байна.

Монгол Улсад сануулах арга хэмжээ нэвтрүүлэхдээ хэн шийдвэр гаргах, ямар баримтад үндэслэх, зөрчил гаргагчийн тайлбарыг хэрхэн харгалзах, шийдвэрийг хэрхэн мэдэгдэх болон түүнийг гомдол гарган хянуулах боломжийг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан тодорхойлох шаардлагатай Ингэснээр сануулах арга хэмжээг дур мэдэн, зохистой хэрэглэх эрсдэлийг бууруулж, хууль ёсны болон үндэслэл бүхий шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ

6.4 Дүгнэлт

Гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад сануулах арга хэмжээг захиргааны зөрчлийн бие даасан шийтгэл болгон хэрэглэх, торгуулийн оронд сонгон хэрэглэх, эсхүл зөрчлийг арилгах хугацаатай мэдэгдэл хүргүүлсний дараа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх зэрэг хэд хэдэн хэлбэрээр зохицуулж байна.

Герман Улсын жишээнд зөрчил ялимгүй шинжтэй тохиолдолд төлбөртэй болон төлбөргүй сануулга өгөх журмыг зохицуулсан бол ОХУ-д сануулгыг захиргааны шийтгэлийн бие даасан төрөл болгон хуульчилжээ. Эдгээр зохицуулалтын сануулах арга хэмжээг зөрчлийн шинж, анх удаа үйлдсэн байдал болон хуульд заасан бусад нөхцөлтэй уялдуулан хэрэглэх боломжийг харуулж байна.

Португалын байгаль орчны зөрчлийн зохицуулалтад сануулга өгөхдөө өмнөх зөрчлийн түүхийг харгалзахын зэрэгцээ зөрчлийг арилгах тодорхой шаардлага тавьж, түүниг биелүүлсэн тохиолдолд зөрчлийн ажиллагааг дуусгавар болгохоор зохицуулсан байна. Их Британийн жишээнд тодорхой үүргийг биелүүлэх тухай бичгээр мэдэгдэл хүргүүлж, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд торгууль ногдуулах механизм тусгагджээ. Харин Францын хөдөлмөрийн хууль тогтоомжид сануулга болон захиргааны торгуулийн аль нэгийг сонгохдоо зөрчлийн нөхцөл, хүндийн зэрэг, зөрчил гаргагчийн зан үйл болон бусад хүчин зүйлийг харгалзахаар зохицуулжээ.

Эдгээр туршлагаас үзэхэд Монгол Улсын Зөрчлийн тухай хуульд сануулах арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг боловсруулахдаа дараах асуудлыг хамтад нь шийдвэрлэх шаардлагатай гэж үзэв

1. Сануулах арга хэмжээ хэрэглэх зөрчлийн төрөл, үндэслэл, нөхцөлийг тодорхойлох;
2. Анх удаа үйлдсэн эсэх, хор уршиг, давтан зөрчил болон зөрчлийг арилгах боломжийг харгалзах шалгуур тогтоох;
3. Сануулга хэрэглэсний дараа шаардлагыг биелүүлээгүй, эсхүл зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;
4. Эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах үндэслэл, ажиллагаа болон шийдвэрийг хянуулах боломжийг хуульчлах.

Иймд сануулах арга хэмжээг Зөрчлийн тухай хуульд тусгахдаа ямар зөрчилд, ямар нөхцөлд сануулга өгөх, сануулга өгсний дараа зөрчлийг арилгаагүй эсхүл дахин үйлдсэн тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэхийг тодорхой зохицуулах шаардлагатай. Ингэснээр зөрчил бүрд торгууль ногдуулахын оронд тохирсон арга хэмжээ авах, зөрчлийг арилгах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.

ДОЛОО ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

7.1. Дүгнэлт

Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг хүчин төгөлдөр хууль тогтоомж, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, иргэдийн санал асуулга, гадаад улсын эрх зүйн зохицуулалт болон асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудын үр нөлөөнд үндэслэн тандан судаллаа. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрэв

Нэгдүгээрт Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийг хуульчилсан боловч сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон тусгаагүй байна. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн судалгаагаар Зөрчлийн тухай хуулийн 1,979 зохицуулалтын 1,952-т торгох шийтгэлийг дангаар буюу бусад шийтгэл, албадлагын арга хэмжээтэй хамтатган хэрэглэхээр заасан нь торгох шийтгэл эрх зүйн зохицуулалтад давамгайлж байгааг харуулж байна. Гэхдээ энэ үзүүлэлт нь бодит хэрэгт торгох шийтгэл зохисгүй хэрэглэгдэж байгааг дангаар нотлохгүй бөгөөд зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал үнэлэгдсэн хохирол, хор уршиг тохирсон мөнгөн бус шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг судлах үндэслэл болж байна

Хоёрдугаарт Зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, торгох шийтгэлийн биелэлт болон эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл нь зөрчлийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох практик хэрэгцээ байгааг харуулж байна. Эдгээр мэдээллийг зөрчлийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход харгалзан үзсэн бөгөөд сануулах шийтгэлийн бодит үр нөлөөг хэрэгжилтийн дараах статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тодорхойлох нь зүйтэй

Гуравдугаарт Иргэдийн цахим санал асуулгад 2026 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаар нийт 993 иргэн оролцож, анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх боломж, уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, шалгуур, хамруулах зөрчлийн төрөл, давтамж болон хэрэгжүүлэх хэлбэрийн талаар саналаа илэрхийлсэн байна. Санал асуулгын үр дүнг сануулах шийтгэлийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага болон хүлээлтийн зохицуулалтын хувилбарыг тодорхойлоход хангалттай гэж үзэв.

Дөрөвдүгээрт Асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг харьцуулан үнэлэхэд одоогийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр хадгалах, олон нийтийг соён гэгээрүүлэх, захиргааны болон зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хувилбарууд нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль хэрэглээний нэгдмэл байдал, бүртгэл хяналт болон шийтгэлийн биелэлтийг сайжруулахад тодорхой үр нөлөө үзүүлэх боломжтой байна. Гэвч эдгээр хувилбар нь Зөрчлийн тухай хуульд заагаагүй санууллах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон оногдуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэхгүй. Иймд санууллах шийтгэлийг хуульчлах хувилбар нь зөрчлийн шинж, хохирол, хор уршиг тохирсон хариуцлагыг ялгамжгай хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх зорилгод илүү нийцэж байна.

Тавдугаарт Санууллах шийтгэлийг бүх төрлийн зөрчилд нийтлэг хэрэглэх бус, хуульд тусгайлан заасан, нийгмийн хор уршиг багатай тодорхой төрлийн зөрчилд хэрэглэх нь зүйтэй гэж үзэв. Үүний тулд зөрчил анх удаа үйлдэгдсэн эсэх, бодит хохирол, хор уршиг учруулсан эсэх, хохирол учрах аюул бий болгосон байдал, зөрчлийн үр дагаврыг зайлшгүй дураар арилгасан эсэх болон давтан үйлдлийн нөхцөлийг хангалттай шаардлагатай Хүний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн эрх, нийтийн аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин болон бусдын эрх хууль ёсны

ашиг сонирхолд нөлөөлөх хохирол, өндөр эрсдэл учруулсан зөрчилд сануулах шийтгэлийг зохистой хэрэглэхээс сэргийлэх нь чухал байна.

Зургаадугаарт. Гадаад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаагаар сануулах арга хэмжээг бие даасан шийтгэл болгон хэрэглэх, торгуулийн оронд ногдуулан хэрэглэх эсхүл зөрчлийг арилгах боломж олгосны дараа шаардлага биелээгүй тохиолдолд харьцуулага хүлээлгэх зэрэг ялгаатай хэлбэрээр зохицуулж байна. Эдгээр туршлагаас үзэхэд сануулах шийтгэлийн эрх зүйн шинж, хэрэглэх үндэслэл, нөхцөл, хязгаарлалт, шийдвэр гаргах ажиллагаа болон давтан зөрчлийн үр дагаврыг тодорхой хуульчлах шаардлагатай байна. Түүнчлэн сануулах шийтгэлийг төрийн хяналт шалгалтын хүрээнд хэрэгжүүлдэг зөвлөн туслах, урьдчилан сануулах, албан шаардлага өгөх арга хэмжээнээс ялган зохицуулах нь зүйтэй.

Долоодугаарт. Сануулах шийтгэлийг нэвтрүүлэх нь Зөрчлийн тухай хуульд шийтгэлийн шинэ төрөл нэмэхээс гадна түүнийг сногдуулах ажиллагаа, шийдвэрийн үндэслэл, бүртгэл, хяналт, гомдол гаргах журам болон давтан зөрчлийн эрх зүйн үр дагаврыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай уялдуулах шаардлагатай. Сануулах шийтгэл хэрэглэх нөхцөл, шалгуурыг тодорхой тогтоож, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэлтэй гаргах хяналтыг боломжийг бүрдүүлснээр ижил нөхцөлтэй зөрчилд ялгаатай шийдвэр гаргах хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах эрсдэлийг бууруулах боломжтой.

Наймдугаарт. Сануулах шийтгэлийг хэрэгжүүлэхэд шийдвэрийн маягт, мэдээллийн нэгдсэн сан, программ хангамж, эрх бүхий албан тушаалтны сургалт болон олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах хэрэгцээ үүсэнэ. Эдгээр ажлыг одоо байгаа байгууллагын бүтэц, хүний нөөц, батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг зардлын тооцоогоор авч үзсэн болович сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээ, давтамжаас хамаарах төсвийн орлого болон хэрэгжилтийн боломт үр нөлөөг цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тогтоох шаардлагатай.

Иймд Зөрчлийн тухай хуульд сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбарыг сонгож, түүнийг хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуур, эрх зүйн үр дагавар, шийдвэр гаргах ажиллагаа, бүртгэл, хяналтын зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсруулах нь зүйтэй гэж дүгнэв.

НОМ ЗҮЙ

1. Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 14-нд өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
2 Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, нэгдүгээр хавсралт.
3. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд иргэдийн санал авах" Google Forms санал асуулга, 993 оролцогч
4. Хууль зүйн яндэсний хүрээлэн. (2025). Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Судалгааны тайлан.
5. Цагдаагийн ерөнхий газраас Улсын Их Хурлын гишүүний ажлын албанд ирүүлсэн зөрчлийн бүртгэл тогтох шийтгэл, түүний биелэлтийн талаарх мэдээлэл 2026 он.
6. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс. Act on Regulatory Offences (Gesetz über Ordnungswidrigkeiten — OWiG), §§56–57
7. Оросын Холбооны Улс.
8.
9.
10. Кодекс Российской Федерации об административных правонарушениях, 2001 №195-ФЗ §3.4
11. Португал Улс. Lei n.º 50/2006 — Lei-Quadro das Contraordenações Ambientais, §47-A
12. Их Британи Environmental Protection Act 1990, §46A
13 Их Британи Noise Act 1996
14. Франц Улс Code du travail, L8115-1, L8115-4–L8115-5 дугаар зүйл.
15. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн "Зарим зөрчилд сануулах арга хэмжээ хэрэглэх боломж", 2026 он

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэхэд чиглэж байна.

Хуулийн төсөл нь гурван зүйлээс бүрдэж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд сануулах шийтгэлийг нэмж, шинээр 3.11 дүгээр зүйлээр уг шийтгэлийн ойлголт, хэрэглэх үндэслэл, нөхцөл, хэлбэр, бүртгэл, давтан зөрчилтэй холбоотой үр дагаврыг зохицуулахаар тусгажээ.

Түүнчлэн сануулах шийтгэлийг үндсэн шийтгэлийн ангилалд хамааруулж, хуулийг 2027 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд анх удаа, бага зэргийн шинжтэй, бодит хохирол, хор уршиг учруулаагүй, эсхүл зөрчлийн үр дагаврыг нэн даруй арилгасан тодорхой төрлийн зөрчилд торгох шийтгэлээс өөр хариуцлагын хэлбэр хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах хүрээнд хүчин төгөлдөр эрх зүйн зохицуулалт, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, иргэдийн санал асуулга, гадаад улсын холбогдох зохицуулалт болон асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг судалсан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах үе шаттайгаар үнэлэв.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээнд хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, товч танилцуулга, хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа, 2021–2025 он болон 2026 оны эхний хагас жилийн зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, иргэдийн цахим санал асуулгын нэгтгэсэн үр дүн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан болон холбогдох хууль тогтоомжийг ашиглав. Эдгээр мэдээлэлд үндэслэн хуулийн төслийн зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон харилцан уялдааг үнэлэв.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль болон "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-д заасан шаардлагын дагуу хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцааны онцлог, хамрах хүрээг харгалзан үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгов.

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ хуулийн төслийн үндсэн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх нөхцөл болон хууль хэрэглээнд үүсэж болзошгүй үр дагаврыг харгалзан дараах дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонголоо.

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Харилцан уялдаа.

2.1. Зорилгод хүрэх байдал

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал болон хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаагаар тодорхойлсон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эсэхийг үнэлэхээр сонгов.

Тухайлбал, сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хуульчилснаар зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэн, хуулийн этгээдэд учрах мөнгөн торгуулийн ачааллыг бууруулах зорилгод хүрэх боломжийг үнэлнэ.

2.2. Ойлгомжтой байдал

"Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн хувьд ойлгомжтой, тодорхой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгахаар сонгов.

Энэ хүрээнд сануулах шийтгэлийн тодорхойлолт, хэрэглэх нөхцөл, шалгуур, шийтгэл сонгох дараалал, бүртгэл, давтан зөрчилтэй холбоотой үр дагаврын зохицуулалтыг үнэлнэ.

2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь иргэн, хуулийн этгээд, хууль хэрэгжүүлэгч байгууллага болон

холбогдох бусад этгээдийн эрх ашиг, хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэхээр сонгов.

Мөн иргэдийн санал асуулгын үр дүн, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны дүгнэлтийг харгалзан үзнэ.

2.4. Харилцан уялдаа

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлэхээр сонгов.

Энэ хүрээнд Зөрчлийн тухай хуулийн Ерөнхий болон Тусгай ангийн зохицуулалтын уялдаа, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэх байдлыг шалгана.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. Зорилгод хүрэх байдлын хүрээнд

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд санууулах шийтгэлийг нэмж, шинээр 3.11 дүгээр зүйлээр уг шийтгэлийн ойлголт, хэрэглэх үндэслэл, нөхцөлийг тодорхойлсон зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангаж чадах эсэхийг үнэлнэ.

Тухайлбал, 3.11 дүгээр зүйлийн 2, 5, 6, 9 дэх хэсэгт заасан санууулах шийтгэл хэрэглэх хүрээ, сонголт, шалгуур нь зөрчлийн шинж, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх боломжийг бүрдүүлж байгаа эсэхийг шалгана.

3.2. Ойлгомжтой байдлын хүрээнд

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлд заасан санууулах шийтгэлийн тодорхойлолт, хэлбэр, бүртгэл, шийтгэл сонгох дараалал, нөхцөл, давтан зөрчилд үзүүлэх үр дагавар болон шийтгэл оногдуулах ажиллагааны зохицуулалт нь хэрэгжүүлэгч этгээдэд ойлгомжтой, тодорхой, хэрэглэхэд эргэлзээ үүсгэхгүйгээр томьёологдсон эсэхийг үнэлнэ.

Мөн хуулийн төслийн бүтэц, хэл зүй, найруулга болон нэр томьёоны хэрэглээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагын хүрээнд шалгана.

3.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын хүрээнд

Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлд санууллах шийтгэлийг нэмэх, шинэ 3.11 дүгээр зүйлээр уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, шалгуурыг тогтоох зохицуулалт нь иргэн, хуулийн этгээд, хууль хэрэгжүүлэгч байгууллагын эрх ашиг, хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Иргэдийн цахим санал асуулгын үр дүн, зөрчлийн статистик мэдээлэл, зардлын тооцооны тайлан болон холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг харгалзан үзнэ.

3.4. Харилцан уялдааны хүрээнд

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Мөн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулсан дагалдах хуулийн төслүүдийн зохицуулалтын харилцан уялдааг үнэлнэ.

Дээрх зохицуулалтууд нь хуулийн төслийн үндсэн агуулгыг бүрдүүлж, дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой тул үр нөлөөний үнэлгээг эдгээр хэсгийн хүрээнд хийхээр тогтоов.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатанд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт, үнэлэх хэсэг, шалгах хэрэгсэл

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Санууллах шийтгэлийг шинээр хуульчилсан зохицуулалт	Үзэл баримтлал, тандан судалгаагаар тодорхойлсон зорилго болон хуулийн төслийн

			зохицуулалтыг харьцуулах
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлийн шаардлагаар шалгах
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад үзүүлэх нөлөө	Иргэдийн санал асуулга, статистик, зардлын тооцоо болон оролцогч талуудын эрх ашиг, хэрэгцээг харьцуулах
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн зүйл, заалтын уялдаа болон аргачлалд заасан шалгах асуултаар үнэлэх

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаагаар тодорхойлсон асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эсэх, зохицуулалт хэрэгжсэнээр хүлээгдэж буй үр дүнд хүрэх боломжтой эсэхийг үнэлэв.

Зөрчлийн тухай хуулийн хүчин төгөлдөр зохицуулалтад сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон тусгаагүй нь тодорхой төрлийн зөрчилд торгохоос өөр мөнгөн бус шийтгэл хэрэглэх боломжийг хязгаарлаж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд энэхүү нөхцөл байдлыг харгалзан зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон хариуцлагын төрөл бий болгох шаардлагыг тодорхойлсон.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаанд одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалах, олон нийтийг соён гэгээрүүлэх, захиргааны болон зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, сануулах шийтгэлийг хуульчлах гэсэн дөрвөн хувилбарыг харьцуулж, сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх хувилбарыг сонгожээ.

Энэ нь хуулийн төслийн зохицуулалт тандан судалгаагаар тодорхойлсон асуудалтай шууд холбоотой байгааг харуулж байна.

Хүснэгт 2. Тандан судалгаагаар тодорхойлсон асуудал, хуулийн төсөлд тусгагдсан байдал

№	Тандан судалгаагаар тодорхойлсон асуудал	Хуулийн төсөлд тусгагдсан байдал
1	Зөрчлийн шинж, хор уршигт тохирсон мөнгөн бус шийтгэлийн сонголт хязгаарлагдмал	3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сануулах шийтгэлийг нэмж, үндсэн шийтгэлийн төрөл болгохоор тусгасан
2	Сануулах шийтгэл оногдуулах эрх зүйн үндэслэл тодорхой бус	Шинэ 3.11 дүгээр зүйлд сануулах шийтгэлийн ойлголт, хэрэглэх нөхцөл, шалгуурыг тодорхойлсон
3	Анх удаа үйлдсэн, хохирол, хор уршиг багатай тодорхой зөрчилд ялгамжтай хариуцлага хэрэглэх боломж шаардлагатай	3.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зөрчлийг анх удаа үйлдсэн, бодит хохирол учруулаагүй, үр дагаврыг арилгасан нөхцөлийг харгалзахаар тусгасан
4	Сануулах шийтгэлийн бүртгэл, баримтжуулалт шаардлагатай	3.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт цаасан, цахим хэлбэр болон мэдээллийн нэгдсэн санд бүртгэх зохицуулалтыг тусгасан

5	Давтан зөрчилд хариуцлага хэрэглэх асуудлыг тодорхой болгох шаардлагатай	3.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт өмнө сануулах шийтгэл оногдуулсан нь дахин зөрчил үйлдсэн тохиолдолд бусад шийтгэл оногдуулахад саад болохгүй гэж тусгасан
6	Шийтгэл оногдуулах ажиллагааг процессын хуультай уялдуулах шаардлагатай	3.11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг болон дагалдах хуулийн төслөөр шийдвэрлэхээр тусгасан
7	Сануулах шийтгэл хэрэглэх тодорхой зөрчлийн хүрээг тогтоох шаардлагатай	3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсэгт тусгасан боловч эдгээр хэсгийн харилцан уялдааг тодруулах шаардлагатай

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт сануулах шийтгэлийг зөвхөн Тусгай ангид оногдуулж болохоор заасан тохиолдолд хэрэглэхээр тусгасан атлаа 9 дэх хэсэгт арваас таван зуун нэгжийн торгуулийн хүрээнд хэрэглэхээр заасан байна.

Эдгээр зохицуулалтаас Тусгай ангид сануулах шийтгэлийг тусгайлан заагаагүй боловч торгуулийн хэмжээ нь дурдсан хүрээнд багтсан зөрчилд сануулах шийтгэл оногдуулах боломжтой эсэх нь тодорхой бус байна.

Иймд сануулах шийтгэлийг хэрэглэх хүрээг нэг мөр тодорхойлохгүй бол хуулийн төслийн зорилго бүрэн хэрэгжихэд хүндрэл үүсэх боломжтой.

Түүнчлэн 3.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт сануулах шийтгэлийг эхний ээлжид сонгохоор, 6 дахь хэсэгт тодорхой нөхцөлийг харгалзан оногдуулж болохоор тусгасан нь уг шийтгэлийг ямар нөхцөлд заавал, ямар нөхцөлд сонгон хэрэглэхийг тодруулах шаардлагатайг харуулж байна.

Иймээс сануулах шийтгэлийг шинээр нэвтрүүлэх нь хуулийн төслийн зорилготой нийцэж байгаа боловч хэрэглэх хүрээ, нөхцөл, шалгуурын уялдааг хангах шаардлагатай гэж үнэлэв.

4.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан бүтэц, агуулга, хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгав.

Хуулийн төсөл нь гурван зүйлээс бүрдсэн бөгөөд сануулах шийтгэлийг шинээр хуульчлах, шийтгэлийн ангилалд нэмэх, дагаж мөрдөх хугацааг тогтоох гэсэн үндсэн зохицуулалтыг тусгасан байна.

Гэвч зарим зүйл, хэсэгт агуулгын давхардал, хоёрдмол ойлголт үүсэх боломж ажиглагдав.

Хүснэгт 3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагын үнэлгээ

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага	Үнэлсэн байдал
1	29.1.1. Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байх	Сануулах шийтгэлийг хуульчлах зорилго нь эрх зүйн үндсэн зарчимтай нийцэх боломжтой боловч хүний эрхийн баталгаа, процессын зохицуулалтын уялдааг нарийвчлах шаардлагатай
2	29.1.2. Зохицуулах харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгах	Сануулах шийтгэлийн үндсэн ойлголт, нөхцөлийг тусгасан боловч Тусгай анги хэрэглэх зөрчлийн хүрээ бүрэн тодорхой болоогүй
3	29.1.3. Зохицуулах харилцааны хүрээнээс хальсан асуудал тусгахгүй байх	Сануулах шийтгэлийг нэвтрүүлэхтэй шууд холбоогүй зохицуулалт илрээгүй
4	29.1.4. Үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх	Төслийн зохицуулалт Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хамаарч байна

5	29.1.5. Зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилгүй байх	3.11 дүгээр зүйлийн 2, 9 болон 5, 6 дахь хэсгийн харилцан уялдааг тодруулах шаардлагатай
6	29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй тунхагласан шинжтэй заалт тусгахгүй байх	Төслийн үндсэн заалтууд нь санууулах шийтгэл хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ тогтоож байна
7	29.1.7. Бусад хуулийг давхардуулан заахгүй, шаардлагатай тохиолдолд эшлэлийг тодорхой хийх	3.11 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн процессын хуулийн эшлэлийг засах шаардлагатай
8	29.1.8. Эрх, үүрэг, чиг үүрэг, эрх хэмжээ, хэрэглэх нөхцөлийг тодорхой тусгах	Санууулах шийтгэл хэрэглэх эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, шалгуур, бүртгэл, гомдол гаргах асуудлыг процессын хуультай уялдуулан нарийвчлах шаардлагатай

Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэглэхэд 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсгийн хооронд санууулах шийтгэл хэрэглэх хүрээний талаар хоёрдмол ойлголт үүсэх боломжтой байна.

Мөн 3.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан нөхцөлүүдийг бүгдийг зэрэг хангах эсэх, эсхүл аль нэг нөхцөлийг харгалзан санууулах шийтгэл оногдуулах боломжтой эсэхийг тодорхой заагаагүй байна.

Эдгээр асуудал нь хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнууд ижил шинжтэй зөрчилд ялгаатай шийдвэр гаргах эрсдэл үүсгэж болзошгүй.

Хүснэгт 4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын шаардлагын үнэлгээ

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага	Үнэлсэн байдал
1	30.1.1. Үндсэн хууль болон бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх	"Зөрчил гаргасан" гэсэн хэллэгийг "зөрчил үйлдсэн" гэсэн нэр томьёотой нэг мөр болгох шаардлагатай
2	30.1.2. Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголт илэрхийлэхгүй байх	Сануулах шийтгэлийг урьдчилан сануулах, зөвлөн туслах арга хэмжээнээс тодорхой ялгах шаардлагатай
3	30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн, хоёрдмол утгагүй товч, тодорхой бичих	3.11 дүгээр зүйлийн 2, 9 болон 5, 6 дахь хэсгийн найруулга, уялдааг тодруулах шаардлагатай
4	30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх	Төслийн үндсэн зохицуулалтад энэ төрлийн асуудал илрээгүй
5	30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Төслийн нэр томьёо, өгүүлбэрийн найруулгыг эцсийн редакцын шатанд нэг мөр шалгах шаардлагатай

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт сануулах шийтгэлийг "энэ хуульд заасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу" оногдуулахаар тусгасан нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулах харилцааг ялгаж тодорхойлоход эргэлзээ үүсгэж байна.

Иймд процессын журмыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай зөв уялдуулан найруулах шаардлагатай.

Түүнчлэн хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хэрэглэсэн "үр дагаварыг" гэсэн үгийг зөв бичих дүрмийн дагуу "үр дагаврыг" гэж засах шаардлагатай.

Үнэлгээний дүгнэлт: Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулалтын чиглэл ойлгомжтой боловч сануулах шийтгэл хэрэглэх хүрээ, нөхцөл, шалгуур, шийтгэл сонгох дараалал болон процессын хуулийн эшлэлд тодруулга хийх шаардлагатай гэж үнэлэв.

4.3. "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг иргэн, хуулийн этгээд, хууль хэрэгжүүлэгч төрийн байгууллага болон бусад холбогдох этгээдийн эрх ашиг, хэрэгцээ, шаардлага, нийгмийн хүлээлтэд нийцэж байгаа эсэхийн хүрээнд үнэлэв.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаанд анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчилд мөнгөн торгуулиас өөр шийтгэлийн төрөл хэрэглэх хэрэгцээ байгааг тодорхойлсон байна.

Зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээллээр 2021–2025 онд нийт 16,064,538 зөрчил бүртгэгдэж, шийтгэл оногдуулсан талаар үзэл баримтлал, танилцуулгад дурдсан.

Мөн 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4,353,418 зөрчил бүртгэгдсэн бөгөөд 4,141,611 хүн, 178,341 хуулийн этгээдэд нийт 114.3 тэрбум төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 58.3 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 51.0 хувь нь төлөгдсөн гэж мэдээлжээ.

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах хүрээнд 2026 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд цахим санал асуулга зохион байгуулж, нийт 993 иргэний саналыг нэгтгэсэн байна.

Санал асуулгаар анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх зохицуулалтыг дэмжиж байгаа эсэх, уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хамруулах зөрчлийн төрөл, давтамж болон хэрэгжүүлэх хэлбэрийн талаарх оролцогчдын байр суурийг тодруулсан.

Санал асуулгын үр дүнг хуулийн төслийн зохицуулалтын хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, хэрэглэх нөхцөл, шалгуур болон хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхэд харгалзан үзэв.

Уг санал асуулга нь иргэдийн сайн дурын оролцоонд тулгуурласан тул үр дүнг зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл, хууль тогтоомжийн шинжилгээ болон холбогдох бусад судалгааны үр дүнтэй хамтатган үнэлэв.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайланд иргэн, хуулийн этгээдэд шинээр үүрэг ногдуулахгүй, шинэ татвар, төлбөр, хураамж, зөвшөөрөл, бүртгэлийн шаардлага бий болгохгүй гэж дүгнэсэн.

Мөн шинэ байгууллага, нэмэлт орон тоо, бүтэц бий болгохгүй бөгөөд сануулах шийтгэлийн бүртгэлийг одоо ашиглаж байгаа мэдээллийн системд нэмэлт, өөрчлөлт хийх замаар хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн.

Сануулах шийтгэлийг хуульчлах нь тодорхой төрлийн зөрчилд мөнгөн бус хариуцлага хэрэглэх боломжийг нэмэгдүүлж, иргэн, хуулийн этгээдийн мөнгөн торгуулийн ачааллыг бууруулах боломжтой.

Зардлын тооцоонд шинээр шаардагдах нэмэлт санхүүжилтийг 0 төгрөгөөр тооцсон нь сануулах шийтгэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалт, мэдээллийн системийн өөрчлөлт, бүртгэл, хяналт болон олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг холбогдох байгууллагуудын батлагдсан төсөв, одоо байгаа бүтэц, хүний нөөцийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна. Иймд хэрэгжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулахдаа холбогдох байгууллагуудын төсөв, техникийн нөөц болон хүний нөөцийн хүрэлцээг харгалзан үзэх нь зүйтэй.

Харин хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хэрэглэгчийн эрх, нийтийн аюулгүй байдалд бодит хохирол, ноцтой эрсдэл учруулах зөрчилд сануулах шийтгэлийг хэт өргөн хэрэглэх нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгод сөргөөр нөлөөлж болзошгүй.

Мөн сануулах шийтгэл оногдуулах шалгуур тодорхой бус байвал ижил шинжтэй зөрчилд ялгаатай шийдвэр гаргах эрсдэлтэй.

Хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхдээ иргэдийн санал асуулгын үр дүнгээс гадна зохицуулалтыг хэрэгжүүлэх төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, худалдаа, үйлчилгээ эрхлэгчид болон хүний эрх, хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын эрх ашиг, хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх нь зүйтэй.

Үнэлгээний дүгнэлт: Хуулийн төсөл нь зөрчлийн шинж, хохирол, хор уршигт тохирсон мөнгөн бус шийтгэлийн сонголтыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд иргэдийн санал асуулга, статистик мэдээлэл болон хэрэгжилтийн зардлын тооцоог харгалзан үзэхэд зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагатай уялдаж байна. Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд оролцох эрх бүхий байгууллага, мэргэжлийн холбоо болон холбогдох бусад этгээдийн саналыг нэгтгэн тусгах нь зохицуулалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үнэлэв.

4.4. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн харилцан уялдааг "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-д заасан шалгах асуултын хүрээнд үнэлэв.

Үнэлгээг хийхдээ хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчил үүсэх боломжтой эсэхийг шалгав.

Хүснэгт 5. Хуулийн төслийн харилцан уялдааг шалгасан байдал

№	Шалгах асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Нийцэж байна. Сануулах шийтгэлийг шинээр нэвтрүүлэх нь зөрчлийн шинж, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх зорилготой шууд холбоотой
2	Хуулийн төсөлд эшилсэн хууль тогтоомж тухайн зохицуулах харилцаанд хамаарах эсэх	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь тухайн харилцаанд шууд хамаарна
3	Төсөлд хэрэглэсэн нэр томьёо бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	"Зөрчил гаргасан" болон "зөрчил үйлдсэн" зэрэг хэллэгийг нэг мөр болгох шаардлагатай
4	Хуулийн төслийн зүйл, заалт хоорондоо болон бусад хуультай нийцэж байгаа эсэх	3.11 дүгээр зүйлийн 2, 9 болон 5, 6 дахь хэсгийн уялдааг тодруулах шаардлагатай
5	Хуулийн төслийн зүйл, заалт давхардсан эсэх	2, 9 дэх хэсгийн сануулах шийтгэл хэрэглэх хүрээний зохицуулалт давхардсан, хоёрдмол ойлголт үүсгэх боломжтой
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэхээр тусгасан боловч

		процессын ажиллагааг дагалдах хуультай уялдуулах шаардлагатай
7	Шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тусгай ангид сануулах шийтгэл оногдуулах зөрчлийн хүрээ, шийдвэрийн хэлбэр, гомдол хянан шийдвэрлэх асуудлыг бүрэн тодорхойлох шаардлагатай
8	Төрийн байгууллагын чиг үүргийг давхардуулсан эсэх	Шинэ байгууллага, чиг үүрэг бий болгох зохицуулалт тусгаагүй боловч мэдээллийн бүртгэлийн ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд уялдуулах шаардлагатай
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Сануулах шийтгэл оногдуулах нь төрийн эрх бүхий албан тушаалтны хуулиар тогтоосон бүрэн эрхэд хамаарна
10	Шинэ албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй. Зардлын тооцоонд иргэн, хуулийн этгээдэд шинэ татвар, төлбөр, хураамж бий болгохгүй гэж дүгнэсэн
11	Шинээр тусгай зөвшөөрөл бий болгосон эсэх	Үгүй. Шинэ зөвшөөрөл, бүртгэлийн шаардлага тусгаагүй
12	Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарлах зохицуулалт байгаа эсэх	Сануулах шийтгэл нь зөрчил үйлдсэнийг тогтоосон хариуцлагын шийдвэр тул гомдол гаргах эрх, тэгш байдал, мэдээллийн хамгаалалтын баталгааг хангах шаардлагатай

13	Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хүйсээр ялгаварласан зохицуулалт тусгаагүй. Хэрэгжилтэд ялгаварлал үүсэхгүй байх зарчмыг баримтлах шаардлагатай
14	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт байгаа эсэх	Шууд ийм зохицуулалт тусгаагүй. Гэхдээ аж ахуйн нэгжүүдэд шийтгэл ялгамжтай хэрэглэх эрсдэлийг бууруулах шаардлагатай
15	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт байгаа эсэх	Ийм зорилготой зохицуулалт байхгүй боловч шийтгэл сонгох шалгуур тодорхой бус байвал албан тушаалтны үзэмж хэт өргөжих эрсдэлтэй
16	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгасан эсэх	Сануулах шийтгэлийн төрлийг тусгасан боловч хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, процессын журмыг тодорхой болгох шаардлагатай

Хуулийн төслийн харилцан уялдааг үнэлэхэд сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх зохицуулалт нь Зөрчлийн тухай хуулийн Ерөнхий ангид шинэ хэм хэмжээ тогтоох зорилготой нийцэж байна.

Гэхдээ сануулах шийтгэлийг зөвхөн Тусгай ангид заасан тохиолдолд хэрэглэх зохицуулалт болон торгуулийн хэмжээгээр хэрэглэх хүрээг тогтоосон зохицуулалтын хоорондтодорхой бус байдал байна.

Мөн сануулах шийтгэл оногдуулах ажиллагааны журам, шийдвэрийн бүртгэл, гомдол гаргах, хянан шийдвэрлэх асуудлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай уялдуулах шаардлагатай.

Сануулах шийтгэл оногдуулсан мэдээллийг бүртгэхтэй холбоотойгоор хувийн мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалах нөхцөл, мэдээллийн сангийн нэвтрэх эрхийг тодорхой болгох хэрэгтэй.

Түүнчлэн сануулах шийтгэл хэрэглэх нь хохирогчийн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй байх шаардлагатай.

Иймд "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь холбогдох хууль тогтоомжтой нийцэх боломжтой боловч тодорхой хэсгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж, дагалдах хуулийн төслүүдийн уялдааг хангах шаардлагатай гэж үнэлэв.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэв.

Хуулийн төсөл нь сануулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуулийн Ерөнхий ангид бие даасан шийтгэлийн төрөл болгон хуульчлах замаар зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Үнэлгээний хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа, статистик мэдээлэл, иргэдийн санал асуулгын нэгтгэсэн үр дүн болон зардлын тооцооны тайланг харгалзан хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэв.

5.1. Баримтжуулалт

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийхдээ дараах баримт, мэдээллийг ашиглав.

- Хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийн талаарх танилцуулга;
- Хуулийн төслийн үзэл баримтлал, товч танилцуулга;
- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа;
- Зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн 2021–2025 он болон 2026 оны эхний хагас жилийн статистик мэдээлэл;
- Иргэдийн цахим санал асуулгын нэгтгэсэн үр дүн;
- Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан;
- Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалт.

Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос ирүүлэх албан ёсны саналыг хүлээн авсны дараа саналын нэгтгэл, хүлээн авсан болон хүлээн аваагүй саналын үндэслэлийг тайланд нэмж тусгах шаардлагатай.

5.2. Үнэлэлт, дүгнэлт

5.2.1. Зорилгод хүрэх байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн үндсэн зорилго нь зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, анх удаа, хохирол, хор уршиг багатай тодорхой зөрчилд мөнгөн бус шийтгэл хэрэглэх эрх зүйн боломжийг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлд сануулах шийтгэлийг шинээр нэмэх, 3.11 дүгээр зүйлээр уг шийтгэлийн ойлголт, үндэслэл, нөхцөлийг тогтоох зохицуулалт нь хуулийн төслийн зорилготой нийцэж байна.

Гэвч сануулах шийтгэл хэрэглэх хүрээг зохицуулсан 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсгийн уялдаа тодорхой бус байгаа нь уг шийтгэлийг бодитоор хэрэгжүүлэх боломжид нөлөөлж болзошгүй.

Иймд "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой боловч сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээ, нөхцөл, шалгуурыг тодорхой болгох шаардлагатай гэж үнэлэв.

5.2.2. Ойлгомжтой байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн бүтэц, зүйл, хэсэг, заалтын агуулга, нэр томьёоны хэрэглээ болон зохицуулалтын логик дараалалыг үнэлэхэд сануулах шийтгэлийг шинээр нэвтрүүлэх үндсэн зохицуулалт тодорхой байна.

Гэхдээ 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсэг, 5, 6 дахь хэсэгт сануулах шийтгэл хэрэглэх хүрээ болон шийтгэл сонгох нөхцөлийн талаар хоёрдмол ойлголт үүсэх боломжтой.

Мөн процессын журмыг зохицуулсан хэсгийн эшлэл, "зөрчил гаргасан" болон "зөрчил үйлдсэн" зэрэг нэр томьёоны хэрэглээг нэг мөр болгох шаардлагатай.

Иймд "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үндсэн агуулга ойлгомжтой боловч холбогдох хэсгүүдийг нэмж тодруулах шаардлагатай гэж дүгнэв.

5.2.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах хүрээнд 2026 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 3-ны өдрийн хооронд иргэдийн цахим санал асуулгыг зохион байгуулж, нийт 993 иргэний саналыг нэгтгэсэн байна.

Санал асуулгаар анх удаа, бага зэргийн шинжтэй зөрчилд сануулах шийтгэл хэрэглэх зохицуулалтыг дэмжиж байгаа эсэх, уг шийтгэлийг хэрэглэх нөхцөл, хамруулах зөрчлийн төрөл, хэрэглэх давтамж болон хэрэгжүүлэх хэлбэрийн талаарх оролцогчдын байр суурийг тодруулжээ.

Санал асуулгын үр дүнг сануулах шийтгэлийн зохицуулалтыг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, хэрэглэх нөхцөл, шалгуур, хамрах хүрээг тодорхойлох болон хуулийн төслийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхэд харгалзан үзэв.

Уг санал асуулгыг цахим хэлбэрээр, сайн дурын оролцоонд тулгуурлан явуулсан тул үр дүнг хууль тогтоомжийн шинжилгээ, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон холбогдох бусад судалгааны үр дүнтэй хамтатган үнэлэв.

Иймд "Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сануулах шийтгэлийг нэвтрүүлэх зохицуулалт нь тандан судалгаагаар тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа бөгөөд иргэдийн санал асуулга, зөрчлийн статистик мэдээлэл болон хэрэгжилтийн зардлын тооцоог харгалзан үзэхэд хуулийн төслийн зорилгыг дэмжиж байна гэж үнэлэв. Холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоо болон бусад оролцогч талуудын саналыг нэгтгэн тусгах нь уг зохицуулалтын хэрэгжих боломж, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой.

5.2.4. Харилцан уялдааны үнэлгээний үр дүн

Хуулийн төслийн харилцан уялдааг шалгахад сануулах шийтгэлийг бие даасан шийтгэлийн төрөл болгон хуульчлах зохицуулалт нь Зөрчлийн тухай хуулийн Ерөнхий ангид шинэ хэм хэмжээ тогтоох зорилготой нийцэж байна.

Гэхдээ 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсгийн хооронд сануулах шийтгэл хэрэглэх хүрээ, 5, 6 дахь хэсгийн хооронд шийтгэл сонгох нөхцөл, шалгуурын талаар тодорхой бус байдал байна.

Мөн сануулах шийтгэл оногдуулах ажиллагаа, шийдвэрийн бүртгэл, гомдол гаргах болон шийдвэрийг хянан шийдвэрлэх асуудлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай уялдуулах шаардлагатай.

Иймд "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь холбогдох хууль тогтоомжтой нийцэх боломжтой боловч зарим зүйл, хэсгийн уялдааг нэмж хангах шаардлагатай гэж дүгнэв.

5.3. Зөвлөмж

Хуулийн төслийн чанар, ойлгомжтой байдал, практикт хэрэгжих боломжийг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг гаргав.

1. Сануулах шийтгэл хэрэглэх зөрчлийн хүрээг тодорхой болгох.

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсгийн уялдааг хангаж, сануулах шийтгэлийг зөвхөн Тусгай ангид заасан зөрчилд хэрэглэх эсэх, торгуулийн хэмжээний шалгуурыг хэрхэн харгалзахыг нэг мөр тогтоох шаардлагатай.

2. Сануулах шийтгэл хэрэглэх нөхцөл, шалгуурыг нарийвчлах.

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан нөхцөлүүдийг бүгдийг нь зэрэг хангах шаардлагатай эсэх, эсхүл аль нэгийг харгалзан сануулах шийтгэл оногдуулах боломжтой эсэхийг тодорхой болгох нь зүйтэй.

3. Шийтгэл сонгох дарааллыг тодорхой болгох.

Хуулийн төслийн 3.11 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсгийн уялдааг хангаж, сануулах шийтгэлийг ямар нөхцөлд эхний ээлжид сонгох, ямар тохиолдолд бусад шийтгэл оногдуулахыг тодорхой зохицуулах шаардлагатай.

4. Сануулах шийтгэл оногдуулах ажиллагааг процессын хуультай уялдуулах.

Сануулах шийтгэл оногдуулах шийдвэрийн хэлбэр, агуулга, мэдэгдэх, гардуулах, бүртгэх, гомдол гаргах болон хянан шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай уялдуулан нарийвчлах нь зүйтэй.

5. Сануулах шийтгэлийн бүртгэл, мэдээллийн хамгаалалтыг тодорхой болгох.

Сануулах шийтгэлийг зөрчлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, ашиглах, хадгалах, хамгаалах, давтан зөрчлийг тогтооход хэрэглэх нөхцөл, журмыг тодорхой болгож, хувийн мэдээлэл хамгаалах эрх зүйн шаардлагыг хангах нь зүйтэй.

6. Хуулийн хэрэгжилтийн зардлын тооцоог байгууллагуудын бэлэн байдалтай уялдуулах.

Зардлын тооцоонд шинээр үүсэх нэмэлт зардлыг 0 төгрөг гэж тооцсон үндэслэлийг мэдээллийн системийн өөрчлөлт, сургалт, олон нийтэд мэдээлэл түгээх ажлын хэрэгцээ болон холбогдох байгууллагуудын батлагдсан төсвийн хүрэлцээтэй тулган баталгаажуулах шаардлагатай.

7. Хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг шилжилтийн хугацаанд хангах.

Хуулийг дагаж мөрдөхөөс өмнө шийдвэрийн загвар, мэдээллийн системийн өөрчлөлт, албан тушаалтны сургалт, дагалдах хууль тогтоомжийн уялдаа болон хэрэгжилтийн бусад бэлтгэл ажлыг бүрэн хангах шаардлагатай.

8. Хуулийн төслийн статистик болон санал асуулгын мэдээллийг баталгаажуулах.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаанд туссан статистик мэдээлэл, санал асуулгын оролцогчдын тоо, хувийн үзүүлэлтийг анхан шатны мэдээлэлтэй тулган нэг мөр болгох нь зүйтэй.

9. Холбогдох байгууллагуудын саналыг нэгтгэн тусгах.

Хуулийн төсөл хэрэгжүүлэх төрийн байгууллага, хуульчдын мэргэжлийн холбоо, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл, хүний эрх болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн, хүлээн авсан болон хүлээн аваагүй саналын үндэслэлийг баримтжуулах нь зүйтэй.

Дээрх зөвлөмжийг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг боловсронгуй болгох, дагалдах хуулийн төслүүдийн уялдааг хангах, хэрэгжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулахад харгалзан үзэх шаардлагатай.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь сануулах шийтгэлийг бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх замаар зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа, зөрчлийн бүртгэл, шийдвэрлэлтийн статистик мэдээлэл болон иргэдийн цахим санал асуулгын нэгтгэсэн үр дүн нь уг зохицуулалтыг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлагыг судлах үндэслэл болжээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд шинэ байгууллага, нэмэлт орон тоо, бүтэц бий болгохгүй, хэрэгжилтийг одоо байгаа байгууллагуудын батлагдсан төсөв, орон тоо, мэдээллийн системийн хүрээнд хангах боломжтой гэж үзэж, шинээр үүсэх нэмэлт зардлыг нийт 0 төгрөг гэж тооцсон байна.

Үр нөлөөний үнэлгээгээр сануулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд бие даасан үндсэн шийтгэлийн төрөл болгон нэвтрүүлэх зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилготой нийцэж, зөрчлийн шинж, үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршигт тохирсон хариуцлага хэрэглэх эрх зүйн боломжийг нэмэгдүүлэхээр байна гэж дүгнэв.

Хуулийн төслийн хэрэгжилтийг хангахын тулд 3.11 дүгээр зүйлийн 2, 9 дэх хэсэгт заасан сануулах шийтгэл хэрэглэх хүрээ, 5, 6 дахь хэсэгт заасан шийтгэл сонгох нөхцөл, шалгуурын уялдааг нэг мөр тодорхойлох, шийдвэр гаргах, бүртгэх, хянан шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай нийцүүлэх нь зүйтэй. Мөн мэдээллийн систем, эрх бүхий албан тушаалтны сургалт, хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг холбогдох байгууллагуудын төсөв, хүний нөөц, техникийн боломжтой уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж үнэлэв.

-----oOo-----

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

/Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл/

Улаанбаатар хот
2026 он

Агуулга

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдон иргэн, хуулийн этгээдэд гарах зардлын тооцоо

Гурав. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Дөрөв. Дүгнэлт

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг. Зардлын тооцоо хийх үндэслэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно" гэж заасны дагуу Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго чиглэгдэв.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтыг судлан үзэхэд хуулийн төсөл батлагдсанаар зөвхөн төрийн байгууллагад тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна.

Энэхүү хуулийн төсөл нь Зөрчлийн тухай хуульд зөрчлийн төрөлд "сануулах шийтгэл"-ийг нэмж тусгах зорилготой бөгөөд хуулийн төсөл нь шинэ байгууллага байгуулах, шинэ орон тоо бий болгох зохицуулалт агуулаагүй болно.

Хоёр. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоо хийх аргачлал"-д дараах үе шатын дагуу хийхээр зохицуулсан болно. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- Тоон үзүүлэлтийг тооцох;
- Нэмэлт зардлыг тооцож гаргах;
- Хялбарчлах боломжийг шалгах.

Дээрх бүх үе шат нь иргэн, хуулийн этгээдэд дээрх хуулийн зохицуулалтаар шинээр бий болгож байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон тухайн нэг иргэн, хуулийн этгээдээс зарцуулах хугацааг тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгддэг болно.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээдэд нэмэлтээр, шинээр үүрэг оногдуулсан, хэрэгжүүлэхэд

чиглэсэн ямар нэг зохицуулалт тусгагдаагүй бөгөөд аргачлалд заасан дараагийн үе шатыг шалгах шаардлагагүй буюу иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгээгүй байна. Үүнд:

- Иргэн, хуулийн этгээдэд шинэ татвар, төлбөр, хураамж үүсэхгүй.
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдэд нэмэлт үүрэг үүсгэхгүй.
- Тусгай зөвшөөрөл, бүртгэл, зөвшөөрлийн шинэ шаардлага бий болохгүй.
- Бизнес эрхлэх орчинд нэмэлт шаардлага, санхүүгийн ачаалал үүсэхгүй.

Харин эсрэгээрээ Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчлийг анх удаа үйлдсэн, уг зөрчил нь нийгэмд үзүүлэх хор уршиг багатай, зөрчлийг даруй арилгах боломжтой бол шууд торгох бус сануулах шийтгэл оногдуулснаар иргэн, хуулийн этгээдэд эдийн засгийн дарамт тодорхой хэмжээгээр буурах боломжтой юм.

Гурав. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлын тооцоо

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд зөрчлийн нэг шинэ төрөл болох "сануулах шийтгэл"-ийг нэмж байгаатай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хариуцдаг төрийн байгууллагуудад сануулах шийтгэлийг бүртгэх, мэдээллийн санг шинэчлэх үүрэг тусч байна. Иймд төрийн байгууллага, улсын төсөвт үзүүлэх зардлын тооцоог шинжилж үзлээ.

Энэхүү хуулийн төслийн үндсэн зохицуулалт нь шийтгэлийн төрлийг нэмэгдүүлж байгаа боловч үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр чиг үүрэг, шинэ орон тоо, албан тушаал бий болгохгүй бөгөөд одоо хэрэгжиж байгаа зөрчлийн асуудлыг хариуцдаг төрийн байгууллагуудын үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Мөн хуулийн төсөл батлагдсанаар зөрчил хянан шалгадаг эрх бүхий албан тушаалтанд сургалт явуулах, үйл ажиллагаатай холбоотой тодорхой хэмжээний зардал гарах боловч эдгээр арга хэмжээг одоо байгаа зөрчлийн мэдээллийн систем, зөрчил шийдвэрлэх ажиллагааны тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой байна.

Хүснэгт 1: Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл

№	Үүсэх зардлын төрөл	Нөхцөл байдал	Үзүүлэл нөлөөлөл
1	Чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ байгууллага байгуулах эсэх	Үгүй	Зардлын нөлөөлөл үүсэхгүй
2	Чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ орон тоо бий болох эсэх	Үгүй	Зардлын нөлөөлөл үүсэхгүй
3	Чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой тоног төхөөрөмж худалдан авах эсэх	Үгүй	Зардлын нөлөөлөл үүсэхгүй

4	Чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр мэдээллийн систем хөгжүүлэх эсэх	Үгүй. Тусгайлан шинээр бие даасан систем хөгжүүлэхгүй.	Одоо ашиглагдаж байгаа мэдээллийн системд нэмэлт, өөрчлөлт хийх замаар хэрэгжүүлэх
5	Хуулийг хэрэгжүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд сургалт, мэдээлэл өгөх	Тийм	Холбогдох байгууллагуудын батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх
6	Хуулийг олон нийтэд танилцуулах, олон нийтэд мэдээлэх	Тийм	Холбогдох байгууллагуудын батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх

Иймд хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор төрийн байгууллага, улсын төсөвт нэмэлтээр зардал үүсгэхээргүй байна.

Дөрөв. Дүгнэлт

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй байна. Энэ нь одоогийн хуулийн зохицуулалтад байгаа шийтгэлийн төрлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ чиг үүрэг, шинэ орон тоо, бүтэц бий болохгүй мөн иргэн, хуулийн этгээдэд шинэ үүрэг нэмэгдүүлээгүй. Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа зардал, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

Хүснэгт 2. Зардлын тооцооны нэгдсэн дүгнэлт

№	Зардлын төрөл	Дүн
1	Иргэн, хуулийн этгээдэд нэмэлт үүсэх зардал	0 төгрөг
2	Төрийн байгууллагад нэмэлт үүсэх зардал	0 төгрөг
3	Улсын болон орон нутгийн төсөвт шинээр үүсэх зардал	0 төгрөг
4	Нэмэлт орон тоо, бүтэц, байгууллага	0 төгрөг
	Нийт - 0 төгрөг	

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудын батлагдсан төсөв, орон тоо, одоогийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны хүрээнд хангах боломжтой гэж дүгнэв.

---oOo---